

**ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2025 оны 05 дугаар сарын 05-ны өдөр, Даваа гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл:	1-2
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	3-29
1.Төрийн албаны зөвлөлийн 2024 оны үйл ажиллагааны тайлан	3-23
2.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 04 дүгээр дүгнэлт /Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.1 дэх хэсгийн холбогдох заалт Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх, үргэлжлэв/	23-27
3.Хууль, тогтоолоор үүрэг, чиглэл болгосон Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийн тайлан /үргэлжлэв/	27-29

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы
Төрийн байгуулалтын байнгын хорооны
05 дугаар сарын 05-ны өдөр /Даваа гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Ж.Бат-Эрдэнэ ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 25 гишүүнээс 14 гишүүн хүрэлцэн ирж, 56.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 16 цаг 45 минутад Төрийн ордны “Их засаг” танхимд эхлэв.

Томилолттой: Д.Амарбаясгалан, Т.Доржханд, Б.Пүрэвдорж;
Чөлөөтэй: О.Алтангэрэл, Э.Болормаа, С.Бямбацогт, Ц.Сандаг-Очир,
Л.Оюун-Эрдэнэ, О.Номинчимэг;
Эмнэлгийн чөлөөтэй: С.Амарсайхан.

Нэг.Төрийн албаны зөвлөлийн 2024 оны үйл ажиллагааны тайлан

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Төрийн албаны зөвлөлийн дарга Л.Цэдэвсүрэн, мөн зөвлөлийн гишүүн Ц.Амартөгс, Д.Баатарсайхан, Б.Пүрэвдагва, Б.Идэрчулуун, Ажлын албаны дарга В.Жавзан, Маргаан хянан шалгах газрын дарга Ч.Бат-Эрдэнэ, Хүний нөөцийн удирдлага, аудитын газрын дарга С.Нямбаяр, Захиргаа, удирдлагын газрын дарга Б.Гантулга, Мэдээллийн технологийн хэлтсийн дарга Ю.Алтантуяа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, мөн албаны референт Б.Баярсайхан нар байлцав.

Төрийн албаны зөвлөлийн 2024 оны үйл ажиллагааны тайланг Төрийн албаны зөвлөлийн дарга Л.Цэдэвсүрэн танилцуулав.

Тайлантай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар, С.Зулпхар, Б.Батбаатар, Ж.Бат-Эрдэнэ нарын тавьсан асуултад Төрийн албаны зөвлөлийн дарга Л.Цэдэвсүрэн, мөн зөвлөлийн гишүүн Д.Баатарсайхан, Б.Пүрэвдагва нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхар, Ж.Бат-Эрдэнэ нар үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүд Төрийн албаны зөвлөлийн 2024 оны үйл ажиллагааны тайланг хэлэлцэв.

Уг асуудлыг 18 цаг 01 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 04 дүгээр дүгнэлт /Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.1 дэх хэсгийн холбогдох заалт Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх, үргэлжлэв/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Ж.Түвшинжаргал, Байнгын хороодын ажлын албаны

дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Б.Баярсайхан нар байлцав.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 04 дүгээр дүгнэлтийн талаар боловсруулсан Улсын Их Хурлын тогтоолын төслийг Байнгын хорооны дарга Ж.Бат-Эрдэнэ танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар, С.Зулпхар, Э.Одбаяр, Ж.Бат-Эрдэнэ нар үг хэлэв.

Уг асуудлыг 18 цаг 15 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Хууль, тогтоолоор үүрэг, чиглэл болгосон Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийн тайлан /үргэлжлэв/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Хяналт, үнэлгээний Үндэсний хорооны дарга Э.Одбаяр, Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын дарга Ч.Өнөрбаяр, мөн газрын Үнэлгээ, мониторингийн газрын дарга Д.Үүрийнтуяа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Б.Баярсайхан, Үнэлгээ, мониторингийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Алтантуяа, мөн газрын зөвлөх Б.Отгонсүрэн, референт А.Амармэнд, Б.Энхмаа нар байлцав.

Хууль, тогтоолоор үүрэг, чиглэл болгосон Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийн тайлан Улсын Их Хурлын гишүүдийн үгээр үргэлжлэв.

Тайлантай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүд Хууль, тогтоолоор үүрэг, чиглэл болгосон Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийн тайланг хэлэлцэв.

Уг асуудлыг 18 цаг 20 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 3 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 1 цаг 35 минут үргэлжилж, ирвэл зохих 25 гишүүнээс 15 гишүүн хүрэлцэн ирж, 60.0 хувийн ирцтэйгээр 18 цаг 20 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Ж.БАТ-ЭРДЭНЭ

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

*2025 оны 05 дугаар сарын 05-ны өдөр,
Даваа гараг
Төрийн ордон “Их засаг” танхим
16 цаг 45 минут.*

ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Ж.Бат-Эрдэнэ: Танилцуулъя. Жадамбын Бат-Эрдэнэ гишүүн ирсэн, Жудагийн Баярмаа гишүүн ирсэн, Лхагвын Мөнхбаатар гишүүн ирсэн, Эрдэнэбилэгийн Одбаяр гишүүн ирсэн, Одонгийн Цогтгэрэл гишүүн ирсэн, Батын Батбаатар гишүүн ирсэн, Лувсаннямын Гантөмөр гишүүн ирсэн, Одсүрэнгийн Номинчимэг гишүүн ирсэн, Ням-Осорын Учрал гишүүн ирсэн, Лувсанцэрэнгийн Энх-Амгалан гишүүн ирсэн, Баярмагнайн Баярбаатар гишүүн ирсэн, Сархадын Зулпхар гишүүн ирсэн, Нямтайширын Номтойбаяр гишүүн ирсэн, Гончигдоржийн Уянгахишиг гишүүн ирсэн байна. Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж, ирц бүрдсэн тул 2025 оны 5 дугаар сарын 5-ны өдрийн Байнгын хорооны хуралдааныг нээснийг мэдэгдье.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг та бүхэнд танилцуулъя. 3 асуудал байгаа. 1.Төрийн албаны зөвлөлийн 2024 оны үйл ажиллагааны тайлан. 2.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 4 дүгээр дүгнэлт Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн холбогдох зохицуулалт Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх тухай үргэлжлэл. 3.Хууль тогтоолоор үүрэг, чиглэл болгосон Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийн тайланг хэлэлцэнэ үргэлжлэл. Хэлэлцэх асуудал дээр саналтай гишүүд байна уу? Алга байна. Хэлэлцэх асуудалдаа оръё.

Нэг.Төрийн албаны зөвлөлийн 2024 оны үйл ажиллагааны тайлан

Төрийн албаны зөвлөлийн 2024 оны үйл ажиллагааны тайланг хэлэлцэнэ. Ажлын хэсгийг урьж оролцуулъя. Ажлын хэсгийг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хурлын дэгийн тухай хуулийн 115 дугаар зүйл.Хуулиар тусгайлан заасан тайлан, илтгэл, мэдээллийг сонсох, хэлэлцэх. 115.1.Улсын Их Хурлаар хэлэлцэхээр хуульд тусгайлан заасан тайлан, илтгэл, мэдээллийг эрх бүхий байгууллага хуульд заасан хугацаанд Улсын Их хуралд ирүүлнэ. 115.2.6.Хууль тогтоомжоор хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэх талаарх Төрийн албаны зөвлөлийн тайланг ТББХ-нд жил бүр, 115.4.Энэ хуулийн 115.2, 115.3-д заасан тайлан, илтгэл, мэдээллийг Улсын Их Хурал хүлээн авснаас хойш ажлын 3 өдрийн дотор Улсын Их Хурлын мэдээллийн нэгдсэн санд байршуулж, энэ хуулийн 115.2-т заасан тайланд ажлын 10 өдрийн дотор Улсын Их Хурлын Тамгын газар дүн шинжилгээ хийж, холбогдох Байнгын хороо, гишүүдэд тараасан байна гэсэн байгаа.

Ингээд хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя. Төрийн албаны зөвлөлийн 2024 оны тайланг сонсох хүрээнд төрийн албаны, Л.Цэдэвсүрэн Төрийн албаны зөвлөлийн дарга, Б.Пүрэвдагва Төрийн албаны зөвлөлийн гишүүн, Д.Баатарсайхан Төрийн албаны зөвлөлийн гишүүн, Б.Идэрчулуун Төрийн албаны зөвлөлийн гишүүн,

Ц.Амартөгс Төрийн албаны зөвлөлийн гишүүн, В.Жавзан Төрийн албаны зөвлөлийн албаны дарга, Ч.Бат-Эрдэнэ Төрийн албаны зөвлөлийн Маргаан хянан шалгах газрын дарга, С.Нямбаяр Төрийн албаны зөвлөлийн Хүний нөөцийн удирдлага, аудитын газрын дарга, Б.Гантулга Төрийн албаны зөвлөлийн Захиргаа, удирдлагын газрын дарга, Ю.Алтантуяа Төрийн албаны зөвлөлийн Сургалт судалгаа, мэдээллийн нэгдсэн сангийн газрын Мэдээллийн технологийн хэлтсийн дарга.

Төрийн албаны зөвлөлийн 2024 оны үйл ажиллагааны тайлангийн танилцуулгыг Төрийн албаны зөвлөлийн дарга Л.Цэдэвсүрэн танилцуулна. Цэдэвсүрэн даргын микрофон 4 дүгээр микрофоныг нээе.

Л.Цэдэвсүрэн: Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга болон эрхэм хүндэт Улсын Их Хурлын гишүүддээ энэ оройны мэнд хүргэе.

Төрийн албаны зөвлөл 2024 оныхоо үйл ажиллагааг Төрийн албаны хууль тогтоомж болон холбогдох хууль тогтоомжид заасан чиг үүргийн хүрээнд хууль, бодлого болон хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, хүний нөөцийн аудит хийх, ерөнхий болон тусгай шалгалтууд зохион байгуулах, төрийн албаны хүний нөөц бүрдүүлэх, төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөлт, нэгдсэн тоо бүртгэлийг хөтлөх, Төрийн албаны хууль тогтоомжийн хэрэгжилт болон хүний нөөцийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх гэсэн энэ агуулгын хүрээнд үйл ажиллагаагаа чиглүүлж, энэ хүрээнд та бүхэн тайлангаа танилцуулж байна.

Төрийн албаны зөвлөлийн 2024 оны дэлгэрэнгүй тайлан болон тайлангийн хэвлэмэл номыг урьдчилсан байдлаар Улсын Их Хурлын гишүүд болон Байнгын хорооны гишүүддээ хүргүүлсэн. Бид 2024 онд, миний энэ харагдахгүй байна. 2024 онд хуульд заасан төрийн албаны шинэтгэлийн бодлого, стратеги, хүний нөөцийн бодлогын хэрэгжилтийн чиглэлээр болон төрийн албан хаагчийн сургалт, нийгмийн баталгааны хөтөлбөр, төрийн албаны үйл ажиллагаанд хэрэгжиж байгаа хяналт, хэрэгжиж байгаа хөтөлбөр төслийн хяналт шинжилгээ, хөтөлбөр төслийн хүрээнд хяналт шинжилгээг хийсэн. Энд нь суучихдаг юм уу даргаа.

Ж.Бат-Эрдэнэ: 1 рүү суух юм уу? Тийм, өөрөө тэрийгээ харж ярих гэж байна тийм ээ, болох юм уу? Тэгвэл 3 дугаар микрофоныг нээе.

Л.Цэдэвсүрэн: Хяналт шинжилгээ, үнэлгээнүүдийг хийж ажиллалаа. Монгол Улсын урт болон дунд хугацааны бодлогод заасан ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөрт заасан яг төрийн албан хаагчийн үйл ажиллагаатай холбоотой зүйл, заалт, зорилтуудын хяналт шинжилгээ үнэлгээг хийсэн. Энийг яагаад хийх болов гэхээр Төрийн албаны хууль болон 2023 оны манай байгууллагын тайланг Байнгын хороогоор хэлэлцээд, ер нь энэ хууль тогтоомжид заасан хяналт шинжилгээ, үнэлгээний ажлыг төдийлөн сайн бүрэн хийхгүй байна. Энэ дээрээ ТАЗ анхаарах ёстой гэсэн ийм тогтоол гаргасан. Энэний хүрээнд бид үйл ажиллагаагаа нэлээн эрчимжүүлж, холбогдох зорилт арга хэмжээнүүд дээр мониторинг хийж ажиллалаа. Хяналт шинжилгээ, үнэлгээний нэгдсэн дүн 55-аас 71 хувьтай. Яагаад ингээд улсын хөгжлийн бодлого, дунд хугацааны бодлого болон төрийн албаны хууль тогтоомж, ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөрт туссан ЗГ-ын төрийн албаны үйл ажиллагаатай холбоотой зорилтуудын биелэлт ийм санасан хэмжээнд хүртэл бүрэн хэрэгжихгүй байна вэ гэдэг дээр хяналт шинжилгээнүүд хийж үзсэн. Нийт 26

арга хэмжээний 20,7 хувь нь үр дүнтэй хэрэгжиж байна, 71 арга хэмжээ тодорхой үр дүнд хүрсэн байна, 24 нь эрчимжүүлэх шаардлагатай, 5 арга хэмжээ буюу 3,9 хувь нь үр дүн нь тодорхой хэмжээнд дүгнэгдээгүй байна гэдэг үнэлгээ гарсан.

Үүний шалтгаан нөхцөлийг аваад үзэхээр ерөнхийдөө төлөвлөлтийнхөө суурь судалгааг хангалттай сайн хийдэггүй, тооцоолол буруу, төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхдээ үндсэн шалгуур үзүүлэлтийг нь харгалзахгүйгээр шаардлагатай төсөв батлагддаггүйтэй холбоотой байна гэж дүгнэсэн. Төрийн албан хаагчдын сургалт, нийгмийн баталгааны хөтөлбөр ер нь төрийн байгууллагуудын хувьд хамгийн чухал хөтөлбөрийн нэг байдаг. Энэ дээр хяналт шинжилгээ, үнэлгээ хийж үзэхэд төрийн байгууллагуудаас ер нь энэ хөтөлбөртэй байгууллага их цөөхөн байдаг юм байна. 44 байгууллага материал ирүүлснээс 35 нь л яг албан ёсны хөтөлбөртэй. Энэ хөтөлбөрийн маань биелэлт улсын хэмжээнд 72,1 хувийн гүйцэтгэлтэй ингэж гарсан. Бид энэ хөтөлбөр болон хяналт шинжилгээний дүнгүүдийг ингээд зүгээр хэлэлцээд үлдээгээгүй. Бид ЗГХЭГ-т энэнтэй холбоотой бүх зөвлөгөө зөвлөмжүүдээ хүргүүлсэн. Биелэлтийн нөхцөл байдал ийм байна шүү гээд.

Төрийн албаны хуульд энэ төрийн албаны үйл ажиллагаатай холбоотой судалгаа шинжилгээний ажлын зохион байгуулалтыг хангах нь энэ Төрийн албаны зөвлөлийн нэг чиг үүрэг байдаг. Бид энэ ажлыгаа 2024 онд хийхдээ өмнө нь хийгдэж байсан маш олон судалгаа шинжилгээний ажлуудын нэгдсэн зохион байгуулалт хангалтгүй, гарсан зөвлөмж нь яг хэрэгждэг эсэх нь тодорхойгүй, тодорхой нийцэл ер нь хангалтгүй байна гэж үзээд яг энэ чиглэлээр судалгааны ажил хийсэн 2017-гоос 23 онд хийгдсэн нийт 20 судалгааг түүвэр маягаар авч, энэ судалгааны ажлуудыг илүү яаж үр дүнтэй бодитой болгох вэ гэдэг ажлуудыг хийлээ. Энэний дараа ер нь төрийн албанд нэн хэрэгцээтэй байгаа судалгаа шинжилгээнүүдийн сэдэв юу юм бэ гэдгийг төрийн байгууллагуудтайгаа ярилцаж байж, сэдвийн тохиргоонуудыг хийж ажилласан. 24 онд манай байгууллага өөрөө бие дааж 4, бусад байгууллагатай хамтарч 3 судалгаа шинжилгээний ажлыг хийж, ялангуяа төрийн албан хаагчийн хөдөлмөрлөх эрх болон сэтгэл ханамжийн судалгааны том тайланг ТББХ болон Их Хуралдаа хүргүүлсэн байгаа. Судалгаа шинжилгээний ажлыг гүйцэтгэснээрээ бид ер нь хаана алдаа гараад байна, судалгаа шинжилгээ юун дээр төвлөрөх ёстой юм бэ, ямар судалгаа шинжилгээг илүү давуу хийж, тэрний үр дүн, зөвлөгөөг үйл ажиллагаа болон бодлого гаргагч нарт хүргэж, энийгээ хэрэгжүүлж хэвшүүлэх юм бэ гэдэг дээр 24 онд нэлээн анхаарал тавьж ажиллалаа.

Төрийн албаны чадавхыг бэхжүүлэх чиглэлээр энэ дотоод болон гадаадын хөрөнгө оруулалт, санхүүжилтээр маш олон төсөл хөтөлбөрүүд хэрэгждэг. Энэ төсөл, хөтөлбөрүүдийн хэрэгжилтэд манай байгууллага ерөнхийд нь судалгаа хийж, энэ талаар давхардал хийдэл нь хаанаа байна, үр нөлөөг нь дээшлүүлэх талаар зөвлөгөө, үйлчилгээ үзүүлэх ийм үүрэгтэй. Өнгөрсөн хугацаанд бид 2021 оноос хойш төрийн байгууллагууд дээр хэрэгжсэн энэ төслүүдийн судалгаануудыг нэгтгэж авч, 225 төсөл байдаг юм байна. Энэний 21 хувь нь улсын төсвийн санхүүжилтээр, бусад нь гадаадын зээл, тусламжийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж байгаа болон хэрэгжсэн төслүүд байна. Нийт төслийн 39 хувь нь дууссан, 60,1 хувь нь одоо хэрэгжиж байгаа гэсэн ийм дүнтэй гарсан. Гадаадын хөрөнгө оруулалтаар санхүүжиж байгаа төслүүдийн дийлэнх буюу дийлэнх ч биш юм 34,8 хувийг нь буцалтгүй тусламжийн хүрээнд хэрэгжүүлээд ингээд явж байгаа юм байна.

Судалгааны дүнг ингээд аваад үзэхээр энэ хэрэгжиж байгаа нийт төслүүдийн 91 хувь нь Улаанбаатар хотод хэрэгжиж байна. Тэгэхээр бид нарын энэ нөгөө нэг төсөл, хөтөлбөрүүдийн нийцэл болон улсын хэмжээнд бүрэн хэмжээнд хэрэгжиж чадаж байна уу, үгүй юу гэдэг дээр асуудал гарч байгаа учраас ЗГХЭГ-тайгаа уулзалт зохион байгуулж, 8 төрлийн зөвлөмжийг хүргүүлсэн. Эдийн засаг, хөгжлийн яаманд яг энэ улс орнуудын хэрэгжиж байгаа том, том төслүүдийн нэгтгэлийг хариуцаж байгаа гэдэг агуулгаар нь тэр байгууллагад зөвлөмжөө өгч, давхардал хийдлүүд нь энэ дээр байна, үр дүн нь ийм байна шүү гэдгийг хэлж, энэнийхээ дагуу 25 онд ЗГ болон Их Хурал, холбогдох байгууллагуудтайгаа хамтраад ажиллаж байгаа.

Манай байгууллагын нэг гол чиг үүрэг байгаа. Чиг үүргийн шинжилгээ хийхэд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, хүний нөөцөө аудит хэрэгжүүлэх гээд. Бид 2024 онд бүх яам, агентлаг, ЗДТГ-ын бүтэц, зохион байгуулалт дээр хяналт шалгалт явуулсан. Чиг үүргийн шинжилгээг хэрхэн, яаж хийж байгаа юм, яг үнэн бодит байна уу, үгүй юу түүн дээр суурилсан ажлын байруудыг гаргасан уу, ажлын байр нь яг зөв албан тушаалын тодорхойлолт хийгдсэн үү, үгүй юу гэж. Нийт ингээд хийхээр яам, агентлагууд дээр чиг үүргийн үйл ажиллагааны стратеги хөтөлбөр гэж байна. Байхдаа энийгээ яг зөв чиг үүргийн шинжилгээ хийхгүйгээр ЗГ-ын түвшинд батлуулах тохиолдол маш их байна. Ялангуяа 24 онд сонгуулийн дараа шинэ яамнуудын бүтэц өөрчлөгдсөн, Засаг дарга нарын бүтэц өөрчлөгдсөнтэй холбогдуулж чиг үүргийн шинжилгээг хэлбэр төдий хийсэн ийм дутагдлууд зөндөө гарсан. Энийг эхнээс нь нэлээн сайн засуулж, янзалж, алдааг нь засуулах ажлуудыг хийсэн.

Бүх 21 аймгийн ЗДТГ дээр манай байгууллага 2024 онд очиж ажилласан. Ажиллахдаа илүүтэй шалгалт гэдгээсээ илүүтэй тэд нарт мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, болж байгаа асуудлуудыг нь цэгцлэх, болохгүй байгааг нь яг газар дээр нь засуулах ийм ажлуудыг зохион байгууллаа. Бид 24 онд яг энэнийхээ дараа нийт 51 байгууллагын 4695 албан тушаалын тодорхойлолтыг хянасан. Энэ ингээд харахад тоо нь бага юм шиг мөртөөсөө маш их цаг зав авдаг ийм ажил. Энэндээ бид байгууллагууд дээрээ зөвлөн туслах болон мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлж, батлах зөвшөөрлүүдийг олгосон. Харьцангуй 2024 онд энэ албан тушаалын тодорхойлолтын батлах зөвшөөрөл хүссэн санал өмнөх оноос 1,4 дахин нэмэгдсэн. Энэ мэдээж нөгөө Улсын Их Хурлын сонгуулийн дараа байгуулагдсан шинэ ЗГ, орон нутгийн сонгуулийн дараах Засаг дарга нарын бүтэц, орон тоо, зохион байгуулалттай холбоотой байлаа.

Албан тушаалын тодорхойлолтыг тушаал болгоноор нь нэг бүрчлэн ингэж хянаж баталдаг байсныг 2024 онд нэг ижил чиг үүрэг хэрэгжүүлж байгаа албан тушаалын тодорхойлолтыг нэг нийтлэг хэлбэрээр нь баталж хэвшүүлж эхэлсэн. Энэ маш үр дүнтэй ажил болсон гэж үзэж байгаа. Жишээ нь боловсролын газар гэхэд 21 аймаг, нийслэл дээр нэг тодорхойлолт, хэрэгжүүлж байгаа чиг үүрэг нь ижилхэн, газар зүйн байрлалаар өөр. Тэгэхээр яг энэнтэй ижилхэн ажлуудыг нэлээн сайн хийж, албан тушаалын тодорхойлолтыг цэгцлэх, ингэснээр энэ нөгөө өмнө байсан ялгаатай байдлыг нь арилгах, жигдлэх ийм ажлуудыг хийснээр тодорхой эерэг үр дүн гарч байна гэдэг нь одоо хөдөө орон нутагт ажиллахад мэдэгдэж байна. Яагаад гэхээр сонгон шалгаруулалтад энэ их зөв эерэг үр нөлөө үзүүлж байгаа юм байна гэдэг нь харагдсан.

Мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх нь түрүүн хэлдгээр бид нийслэлд сууж байгаа ч гэлээ нийслэлийн байгууллагууд, Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа төрийн байгууллагууд гээд 5000 гаруй төрийн байгууллагуудын 14 мянган албан хаагчдад хүрч ажиллаж чадсан байна 24 онд. Бүх аймгуудыг бараг 2 удаа тойрсон. Аймгууд болон яам, агентлаг, нийслэлийн дүүргүүд дээр хүрч очиж ажилласан. Энэ дээр тэгээд яг нөгөө хуульд заасны дагуу мэргэжил арга зүйн зөвлөгөө дэмжлэг үзүүлэх бүх ажлуудаа нэлээн хангалттай хийлээ гэж манайхан багаараа үзэж байгаа. Ингэснээрээ бид өмнөх оноос сул орон тооны сонгон шалгаруулалтын захиалга 53 хувиар буурсан. Сонгон шалгаруулалтын захиалгаа өгөхөөс эхлээд л алдаа маш их гардаг байсан. Сонгон шалгаруулалттай холбоотой өргөдөл гомдол, томилгооны зөрчлийн тоо өмнөх оноос 16,6 хувиар буурсан. Хууль тогтоомжид өөрчлөлт ороогүй байхад л баахан бүтэц, зохион байгуулалт, албан тушаалын тодорхойлолтыг өөрчилдөг байсан зөрчлүүд ерөнхийдөө арилж, өмнөх оноос энэ зөрчлийн тоо 40 хувиар буурлаа.

Төрийн байгууллага, албан хаагчдын бүртгэлийг цахимжуулах, ялангуяа төрийн албан хаагчийг өөрийнхөө хувийн хэргийн бүртгэлийг цахимаар шалгах боломжийг нь нээснээрээ тоон мэдээлэл болон цахим системийн үйл ажиллагаанд минь нэлээн их үр дүн гарлаа гэж үзэж байна.

Хууль тогтоомжийн хэрэгжилт болон чадахуйн зарчмын хэрэгжилтэд аудит хийх үүрэгтэй. 2019 онд батлагдсан хуулиас, Төрийн албаны хуульд аудитын асуудал тусгагдсанаас хойш бид өнөөдрийг болтол зөвхөн зорилтот аудитыг нэлээн хийдэг байсан. Аймгуудыг сонгож аваад, яамдыг сонгож аваад. 2024 онд бид яг сэдэвчилсэн аудит руу хөрвөж эхэлсэн. Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа төрийн байгууллагуудын мэдээлэл технологийн чиг үүрэг хэрэгжүүлдэг хүний нөөцийн бүрдүүлэлт, сургалт, хөгжлийн бодлогын хэрэгжилт, үр дүн сэдвээр яам, агентлагийн болон нутгийн захиргааны 443 байгууллага дээр хүний нөөцийн аудитыг хийсэн. 578 төрийн албан хаагчийг хамруулж. Энэ аудитаар асуудлууд нэлээн гарсан. Яг мэдээлэл технологийн чиглэлээр хэрэгжүүлж байгаа албан хаагчдын маань тодорхой хувь нь мэргэжлийн бус хүмүүс байна. Яг олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн IT-ийнхны заавал мэдэх ёстой агуулгын хүрээнд шалгалт авахад тодорхой хугацаанд асуудлууд нь нэг их сайн биш байсан. Тэгээд бид аудитынхаа чиглэлээр 11 агуулга бүхий дүгнэлт гаргаад, ЗГ, төрийн албаны манай өөрийн байгууллага болон Цахим хөгжил, инновац, харилцаа яам, аудитад хамрагдсан байгууллагууд руугаа зөвлөмж өгсөн. Энэ зөвлөмжийнхөө хэрэгжилтэд хойноос нь анхаарал хандуулаад ингээд ажиллаж байгаа.

Төрийн албан хаагчийн сургалт, хөгжилтэй холбоотой асуудал дээр бид ЗГХЭГ-тай хамтарч сургалтын төлөвлөгөө хөтөлбөрийг баталж хэрэгжүүлдэг. Энэ хүрээндээ мэдээж Удирдлагын академийн зохион байгуулж байгаа мэргэшүүлэх болон давтан сургалтуудад төрийн албан хаагчид нэлээн сайн хамрагдаж байна. Манай байгууллагын өөрийнх нь зохион байгуулдаг 7-4-10 гэсэн цахим сургалтад төрийн албан хаагчид нэлээн хамрагдаад ингээд явж байна. Одоо бид нарын хүлээгдэж байгаа зүйл юу вэ гэхээр бид төрийн албан хаагчдыг ажлын байран дээр нь сургадаг ийм тогтолцоог ЗГ-ын Хэрэг эрхлэх газрын Удирдлагын академитай хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулаад ингээд явж байна.

Монгол Улсад төрийн албаны стандарт байх ёстой гэдэг асуудал 1995 оноос хойш хуульчлагдсан. 95 онд хуульчлагдсан, 2002, 8, 17 онд энэ ингээд хуульд

стандартын асуудал тусгагдаад байгаа боловч өнөөдрийг хүртэл 24 оны 12 сарын 31-ийг хүртэл энэ бол батлагдаагүй л яваад байсан. 24 онд бид ажлын хэсэг гаргаж, мэргэжлийн байгууллагуудтай хандаж, Монгол Улсын төрийн албаны стандартын төслийг нь боловсруулж, хэлэлцүүлгүүд хийж маш олон төрлийн санал авч, энийгээ 25 оны сая 4 сарын 10-нд батлуулж чадлаа. Одоо энэ стандарт албажаад ирэхээр энийг хэрэгжүүлэх ажлыг улсын хэмжээнд зохион байгуулах ажлыг зохион байгуулна.

Төрийн албан хаагчийн сахилга, хариуцлага болон ёс зүйтэй холбоотой асуудал манай байгууллагын нэг чиг үүрэг байдаг. Энэ нь яаж чиг үүрэг нь орж ирээд байдаг юм гэхээр төрийн албанд ажиллаж байгаа нийт албан хаагчдаас ямар хүмүүс нь сахилгын арга хэмжээ аваад байна, ямар нийт, ямар хүмүүс нь нийтийн албан тушаалд томилогдох эрх хасах ялаар шийтгүүлээд байна гэдэг бүртгэлийг манайх хөтөлдөг. Энэ бүртгэл хөтлөлтийг хийхдээ ЗГ-тай хамтарсан журмаар зохицуулалтаа хийдэг. 2024 онд өмнөх онуудаас сахилгын шийтгэлээр шийтгэгдсэн төрийн албан хаагчийн тоо буурсан үзүүлэлттэй байгаа. 2022 онд 585, 23 онд 426 албан хаагч сахилгын шийтгэлээр шийтгүүлж байсан бол 24 онд энэ нь 368 болж буурч байна. 368 болж буурч байгаа нь нэг талдаа сайн юм шиг боловч нөгөө талдаа нийтийн албанд томилогдох эрх хасаад ял, эрх хасах ялаар шийтгүүлсэн иргэдийн тоон мэдээлэл жоохон өсөөд байгаа. Энэ ямар мэдээлэл байдаг юм бэ гэхээр Эрүүгийн хуульд заасан авлига, албан тушаалын гэмт хэрэг болон бусад хуулийн, гэмт хэргээр үйлдсэн төрийн албанд ажиллаж байгаа эсвэл ажиллаж байгаад түр чөлөөлөгдсөн хүмүүсийн асуудал үүсдэг.

Өнөөдрийн байдлаар яг нийлбэр дүнгээрээ сүүлийн 5 жилийн хугацаагаар 1159 иргэн яг энэ бидний хэлдгээр хар жагсаалтад бүртгэлд орчхоод явж байна. 23 онд ийм ялаар шийтгүүлсэн 217 хүн байсан бол 24 онд энэ нь 363 болж өссөн. Энэ хүмүүсийн 92-оос 98 хувь нь авлига албан тушаалын гэмт хэрэгт холбогдсон. Тэгээд энэ жагсаалтад орсон хүмүүс энийг яагаад бүртгээд байдаг юм бэ гэхээр магадгүй энэ хүмүүс бүртгэл нэгдсэн бүртгэл байхгүй бол хаа нэгэн газар албан тушаал, төрийн албанд ажилд орох магадлалтай, эрсдэл бий байдаг. Тэгэхээр яг төрийн албанд ороход манай систем дээр бүртгэлд орчихсон хүмүүсийг бусад төрийн байгууллагууд төрийн албанд ажилд оруулах боломж нь хязгаарлагдмал байдаг юм. Монгол Улсын төрийн албанд орох гэж байгаа, ялангуяа захиргааны албанд орох гэж байгаа хүмүүсээс бид ерөнхий шалгалтыг жилд 4 удаа аваад зохион байгуулаад хэвшчихлээ. Улсын хэмжээнд 2024 онд 4 удаагийн ерөнхий шалгалтаар давхардсан дүнгээр 17 мянга гаруй иргэн бүртгэгдэж, энэний 75 хувь нь буюу 13 мянга гаруй иргэн төрийн албаны шалгалтад оролцсон. Эд нараас яг тэнцсэн хүмүүс нь 4658 хүн тэнцээд, төрийн албаны нөөц нь бүртгэгдчихсэн байна 2024 онд. Энэ нь өмнөх оноосоо 1,4 хувиар өссөн иргэд, тэнцсэн иргэдийн тоо 7,5 хувиар буурсан.

Яагаад ингээд буурчхав гэхээр 2024 онд энэ ерөнхий шалгалтын тест агуулгын санд баяжилт хийсэн юм. Тэр 1 дүгээр эхний улиралд шалгалт өгөөд тэнцсэн хүмүүсийн тоо 4 дүгээр улиралд шалгалт өгсөн хүмүүсээс арай илүү байгаа. Тэгэхээр 2 дугаар улирлаас эхлээд бид нөгөө шалгалт агуулгын тестийн сандаа өөрчлөлт хийсэн нь магадгүй 3, 4 дүгээр улиралд тэнцсэн хүмүүсийн тоо буурахад нөлөөлсөн байхыг үгүйсгэхгүй. Ерөнхий шалгалт өгч байгаа иргэдийн үнэлгээг өмнөх онтойгоо харьцуулаад үзэхэд Монгол хэл бичгийн болон ур чадварын шалгалт 9 орчим хувиар ахисан үзүүлэлттэй байгаа. Дүн шинжилгээ

хийх чадварын шалгалт тодорхой хэмжээнд буураад байна. Тэгэхээр бид энэ дээр анализ дүгнэлт хийж, тест, болон бусад сангийнхаа асуудлыг яаж цэгцлэх вэ гээд.

Төрийн албан хаагчийн ерөнхий шалгалтыг улирал тутам зохион байгуулснаараа нэг талдаа сул орон тоог илүү хурдан нөхөж чадаж байна. Шалгалт өгөх хугацааны давтамж өндөртэй байгаа нь иргэдэд аягүй их таалагдаж байгаа. Тэгэхдээ нөгөө талдаа гарч байгаа нь болохоор сул орон тоонд нөөцөд бүртгэгдсэн иргэдийн тооны харьцаа яг нөгөө нэг тухайн шалгалт өгч байгаа нөөцийн, шалгалт өгөөд тэнцсэн нөөцийн тоо хоёрын хоорондын зөрөө ерөөсөө нэг их сайн арилахгүй байна. Тэгэхдээ бид ерөнхий шалгалт болон тусгай шалгалт өгөөд нөөцөд бүртгэгдсэн хүмүүсээс төрийн байгууллагад ажилд оруулах ажлыг 24 онд төрийн байгууллагуудтай хамтарч нэлээн сайн хийсэн. Ингэснээрээ төрийн жинхэнэ албанд томилогдсон хүмүүсийн хувь 46,7 хувь буюу өнгөрсөн оныхоос 14, 5 хувиар ахисан. Энэ нь нэг талдаа албан тушаалын тодорхойлолтыг хянахдаа бид албан тушаалын нэршил, чиг үүрэг, зэрэглэлийг нэлээн сайн цэгцэлж өгч чадлаа. Бүх яам, агентлаг ялангуяа нутгийн захиргааны байгууллагууд ахлах мэргэжилтэн, шинжээч, ахлах шинжээч гэсэн албан тушаалууд бий болгосон байсныг яг мэргэжилтэн, ахлах мэргэжилтний түвшин рүү яг аваачиж өгснөөрөө энэ хүмүүсийн нөөцийн ашиглалт нэлээн ахисан гэж үзэж байгаа.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэний төрийн албан дахь хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр холбогдох төрийн байгууллагууд болон Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Үндэсний зөвлөлтэй хамтарч ажилласнаараа хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төрийн албанд ажиллах хувь 28,5 хувиар нэмэгдсэн. Тоон үзүүлэлтийг нь 23 онтой харьцуулахад 1299 албан хаагчаар нэмэгдсэн гэсэн үг. Яах вэ ингээд аваад үзэхээр удирдах албан тушаалтанд ажиллаж байгаа хүний тоо нь цөөхөн 360, гүйцэтгэх албан тушаалд ажиллаж байгаа хүмүүс нь 3409, туслах түвшинд ажиллаж байгаа хүмүүс нь 2000 гаруй хүн байгаа. Албан тушаалын ангилал зэрэглэл нь харилцан адилгүй байгаа ч гэсэн бид хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг Монгол Улсын төрийн албанд ажиллах боломжийг нь хангаж, тоог нь ингэж нэмэгдүүлж байгаа нэг талдаа нэлээн дэвшилттэй ажил болсон гэж үзэж байгаа.

Тусгай шалгалт зохион байгуулдаг манай байгууллага. Тусгай шалгалт гэдэг ерөнхий шалгалтад тэнцсэн иргэдээс төрийн захиргааны байгууллагуудын тодорхой албан тушаалуудад шалгалт өгдөг. Нөгөө талдаа төрийн үйлчилгээний албаны удирдах албан тушаалд шалгалт өгөх процесс нь тусгай шалгалтын журмаар явдаг. Нийт зарлаж байгаа албан тушаалтнуудын маань 47 хувь нь нөхөгдсөн. Нийт зарлаж байгаа албан тушаалтан хэд байсан бэ гэхээр 6029 сул ажлын байрыг төрийн захиргааны байгууллагууд захиалга өгч, зарлуулсан. Энэний 47 аравны, 45 хувь нь нөхөгдсөн. Үлдсэн хэсэг нь яагаад нөхөгдөхгүй байгаа юм бэ гээд. Хувь бага юм шиг боловч энэ 2023 оноос 5 хувиар бид энэний нөхөлтийг өсгөж чадсан. Үлдсэн хэсэг нь яагаад нөхөгдөхгүй байгаа юм бэ гэхээр хүмүүс ерөөсөө бүртгэлд бараг хамрагдахгүй байна. Бүртгүүлсэн иргэд нь хуульд заасан шаардлагуудыг нь хангахгүй байна. Хуульд заасан шаардлага хангасан ч гэсэн иргэд маань нөгөө тест болон бусад шалгалтуудтай тэнцэхгүй байна. Тэгээд зарим нь нөгөө захиалга өгсөн төрийн байгууллагууд захиалгаа цуцалъя гэдэг хүсэлтүүд нэлээн ирж, энэ хувь иймэрхүү жинтэй явж байна.

Ажлын байрны сул орон тоо гарсан тохиолдолд тухайн байгууллагын удирдлагаас авах ёстой арга хэмжээг хуульчилсан боловч энэ процессынх нь

ажиллагаа маш их удаашралтай байна. Хуульд сул орон тоо гарсан даруй 14 хоногт багтаагаад зарлах ёстой. Бид захиалгаа өгөх ёстой. Гэтэл яг практик дээр энэ нь маш их удаашралтай байна. Тийм учраас бид энэ асуудлаар ЗГ-ын Хэрэг эрхлэх болон яам, агентлагуудад зөвлөмж, чиглэл хүргүүлж, сүүлийн 2 сарын хугацаанд ялангуяа сонгон шалгаруулалтын захиалгуудыг нэлээн их эрч хүчтэй авч энэ ажлыг хийж байна. Ингэж хийхгүй бол хэзээ, хэн нь, ямар захиалга өгөхийг нь хүлээгээд суугаад байвал магадгүй төрийн байгууллагууд ялангуяа удирдах албан тушаалтнууд дээр сонгон шалгаруулалтын захиалгууд маш их удаашрах, цаг алдах ийм хандлагууд гараад байна.

Сонгон шалгаруулалтад олон улсын сайн туршлагыг нэвтрүүлэх ялангуяа хөндлөнгийн нөлөөллийг арилгах ажлыг бүрэн хийж чадсан. Үйл ажиллагаа бүрэн цахимжсан. Энэ нь нэг талдаа магадгүй шалгалтад бэлдэж байгаа хүмүүст цаг хугацааны болон янз янзын асуудал үүсдэгээс болж шалгалтдаа тэнцэхгүй байж магадгүй. Тэгэхдээ бид энэ ажлыг илүү чанаржуулах, илүү сайжруулах чиглэлээр холбогдох байгууллагуудтай хамтраад ингээд энэ ажил маань энэ онд үргэлжлээд хийгдэж байгаа.

Төрийн албаны хуульд зааснаар бид төрийн нийт төрийн байгууллагуудын нэгдсэн тоо бүртгэлийг хөтлөх ийм үүрэгтэй манайх. Бид энэ нэгдсэн тоо бүртгэлээ Төрийн албаны хүний нөөцийн удирдлага, мэдээллийн тогтолцоо гэдэг энэ цахим системээрээ бүртгэдэг. Энэ системийг 2024 онд өргөжүүлж нэлээн хэд хэдэн байгууллагуудтай холболт, интеграци хийж ажилласан. Өнөөдрийн байдлаар Монгол Улсад 24 оны нэгдсэн тоо бүртгэл буюу 12 сарын 31-ний байдлаар 4276 төрийн байгууллага 226895 төрийн албан хаагч нэгдсэн системд бүртгэлд орсон. Энэ нь нийт 23 онтойгоо харьцуулбал байгууллагын тоо 37-гоор, албан хаагчийн тоо 399-өөр өссөн үзүүлэлттэй байгаа. Төрийн албан хаагчид маань Монгол Улсын нийт хүн амын 6,5 хувь, ажиллах хүчний 15,9 хувийг эзлээд эзэлж байна. Өмнөх 2 жилийн байдлаасаа яг ерөнхийдөө хэвээрээ. Нийт албан хаагчдын маань 64,3 хувь нь эмэгтэй.../минут дуусав/

Ж.Бат-Эрдэнэ: Болсон уу? 3 номерыг сунгая.

Л.Цэдэвсүрэн: Би маш товчилж байгаа. Яагаад гэхээр гишүүдэд ном нөгөө тараагдчихсан учраас. Ингэж ажиллаж байна. Манай байгууллагын нэг хийдэг зүйл юу вэ гэхэд төрийн албан хаагчийн сонгон шалгаруулалт болон төрийн албаны хууль тогтоомжийн хэрэгжилтэд хянан шалгалтыг явуулдаг. Хяналт шалгалт 3 чиглэлээр явдаг. Төрийн албан хаагчийг сонгон шалгаруулж томилох үйл ажиллагаанд хяналт шалгалт хийдэг. Төрийн жинхэнэ албан хаагч болон төрийн албанд нэр дэвшигчдийн эрх зөрчигдсөн тохиолдолд маргааныг хянан шийдвэрлэдэг. Хамгийн сүүлийнх нь төрд учирсан хохирлыг буцаагаад төрд нь нөхөн төлүүлэх ажлыг зохион байгуулдаг. 2024 онд төрийн жинхэнэ албан хаагчийг сонгон шалгаруулах ажиллагаанд нийт 499 төрийн байгууллага 10588 төрийн албан хаагчийг хамруулж, шалгалтуудыг зохион байгуулсан. Шалгалтын дүнд тодорхой хэмжээний зөрчлүүд гарсан. Гарч байгаа зөрчлийг тухайн үед нь засуулах, үнэхээр хугацаа өгөөд засах боломжгүй бол Төрийн албаны зөвлөл өөрөө хүчингүй болгох, хүчингүй болгосон тохиолдолд төрд учирсан хохирлыг төлүүлэх ажлуудыг зохион байгуулсан.

Өмнө хэлсэн нөгөө нэг мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, туслалцаа үзүүлсний үр дүнд энэ зөрчилтэй томилгоотой хүмүүсийн албан хаагчдын

зөрчилтэй байсан үйл ажиллагаа 23 онтой харьцуулж үзэхэд 3,6 хувиар буурсан байгаа. Хэдийгээр сонгууль явж, маш олон бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлт хийгдсэн ч гэлээ зөрчилтэй томилгооны эзлэх дүн харьцангуй буурч байгаа нь бидний хийж байгаа ажил тодорхой үр дүн үзүүлж байгаа юм болов уу гэж бодож байгаа. Томилох эрх бүхий албан тушаалтан Төрийн албаны зөвлөлийн 25 тогтоолд хамаарах 201 иргэн албан хаагчид хамаарах зөрчлийг арилгуулж, тогтоолын хэрэгжилтийн биелүүлэлтийг нь хангаад явж байна. Бид 2024 онд төрийн албан хаагч иргэнээс төрийн албан хаагчтай холбоотой гомдол 417 гомдол өргөдлийг хүлээж авч, энэ дээрээ хянан шалгалтын ажлуудыг зохион байгуулсан. Маргаан үүсгэж хянан шалгах ажлуудыг нэлээн сайн хийсэн. 2023 оноос 16,6 хувиар энэ маргаантай холбоотой асуудал буурсан байгаа нь нэг үр дүн юм болов уу гэж үзэж байгаа.

Төрд учирсан хохирлын нөхөн төлүүлэлтийн асуудлыг 2024 онд цахим бүртгэл хөтөлж, шүүхэд төлөөлөх эрхээ маш сайн хэрэгжүүлснээр өмнөх оноосоо бид 3 дахин илүү буюу 623 сая төгрөгийг улсын дансанд буцаан төвлөрүүлж чаджээ. Энэ ажлыгаа цаашид үргэлжлүүлээд ингээд хийгээд явна.

Ерөнхийдөө ТАЗ 2024 онд хуулиар хүлээсэн үүргээ хэрэгжүүлж ажиллаж чадлаа гэж үзэж байгаа. Бид нийт давхардсан тоогоор Улсын Их Хурал, Засгийн газар, яам, агентлаг, Засаг дарга нарт нийт 115 удаагийн албан бичиг, зөвлөмж, дүгнэлт, шийдвэрийн төслүүдийг хүргүүлж ажилласан. Энэний үр дүнд манай байгууллагын үйл ажиллагаанд тодорхой эерэг үзүүлэлтүүдийг гаргасан гэж үзэж байгаа. Төрийн, Байнгын хорооны маань тогтоолын биелэлтийг бид нэлээн анхаарч ажилласан 2024 онд. Байнгын хорооны тогтоолын биелэлт маань маш сайн биелэгдсэн гэж дүгнэж байгаа. Дэлгэцэд бид энэ тайлантайгаа уялдуулж ер нь төрийн албаны хууль тогтоомжийг боловсронгуй болгох чиглэлээр саналаа өгөх ёстой байдаг. Өмнө нь маш олон төрлийн санал өгч байсан. Тэгэхдээ энэ удаад бид ярилцаад та бүхэнд тараасан ном дээр 18 төрлийн саналыг тавьчихсан байгаа.

Багцлаад хэлбэл бид өнөөдөр Монголд хэрэгжиж байгаа Төрийн албаны хуулийг Төрийн албаны тухай хууль, Төрийн албан хаагчийн эрх зүйн байдлын хууль болгож салгах нь зүйтэй юм байна гэсэн ийм саналыг манай байгууллага оруулж ирж байгаа. Одоогийн хуулийн энэ байгууллага болон тогтолцоо албан хаагчийн ийм холилдсон хуулийн маань зохицуулалт, дээрээс нь төрийн албаны үйл ажиллагаатай холбоотой, цалин хөлстэй холбоотой 32 хуулийн зохицуулалт, нийгмийн баталгаа болон бусад үйл ажиллагаатай 23 хуулийн ийм зохицуулалтууд энд тэнд байна. Тэгэхээр энийг цэгцэлж, төрийн албаны тогтолцоо, зарчим, стандарт, санхүүжилт, ангилал, чиг үүргийг тодорхойлсон суурь хууль нь Төрийн албаны хууль байг. Төрийн албан хаагчийн эрх зүйн байдлыг тодорхойлсон бие даасан хууль байвал ямар юм бэ гэсэн ийм саналыг багаараа хэлэлцэж гаргаад, та бүхэнд танилцуулж байгаа юм. Товч танилцууллаа, баярлалаа. Та бүхний асуултад хариулахад манай баг бэлэн байна.

Ж.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Төрийн албаны зөвлөлийн 2024 оны тайлантай холбоотойгоор асуулт асуух гишүүд байна уу, нэрсээ өгнө үү? Батбаатар гишүүнээр тасаллаа. Баярбаатар гишүүн асуултаа асууя.

Б.Баярбаатар: Төрийн албаны тайлантай ч өмнө зөндөө танилцсан, тараасан материалуудтай танилцчихсан. Нэг их айхтар асуулт гээд байх зүйл ч

алга л байна. Зүгээр Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагаа боломжийн түвшинд нэлээн идэвхтэй ажиллаж байгаа гэж харж байгаа. Зүгээр энэ 20-оос 24 оны энэ 3Г-ын үйл ажиллагааны хөтөлбөрт туссан энэ заалтууд 9-хөн хувь биелэлттэй байгаад байгаа юм. Энийг энэ яагаад биелэлтийн багатай байгаа гэдгээр нь магадгүй энэ Их Хурлын Тамгын газрын үнэлгээ дээр байна л даа. Тэгэхдээ Төрийн албаны зөвлөл энэ дээр нэг тодорхой хариулаад өгвөл, үндсэн чиглэл 2-ын. Үндсэн чиглэлийнх нь 40 гаруй хувьтай, 3Г-ын үйл ажиллагааны хөтөлбөр 9-хөн хувь гэж байгаа байхгүй юу. Тэгээд дотор заалтуудыг нь уншаад үзэхээр зарим нь биелчих боломж нөхцөл байдал харагдаад байсан ч юм шиг иймэрхүү л зүйлүүд ажиглагдаад байгаа юм.

Ер нь зүгээр цаашдаа энэ тайлан, энэ үнэлгээ хийдэг зүйлийг энэ 3Г Их Хурлын хяналт шалгалт 2 энэ аргачлалуудаа жоохон нэгтгэхгүй бол энэнээс чинь болоод ингээд сүүлд нь асуудал үүсээд байна. Би энэ 3Г-ын үйл ажиллагааны хөтөлбөр 9-хөн хувьтай хэрэгжсэн байдлыг миний хувьд зүгээр харахдаа энэ 3Г энэ Байнгын хороо болон Их Хурлын тогтоолуудыг ерөөсөө хэрэгжүүлэхгүй байгаа юм л даа. Их Хурал нь нэг тогтоол батлаад өгнө, Байнгын хороо нэг тогтоол батлаад өгнө, чиглэл хүргүүлэх тухай гээд явуулчихна. Тэгээд л тэд нар нь ерөөсөө огт хэрэгждэггүй. Тэгээд хэрэгжилтийг нь ингээд нэхэж шаардахаар өөдөөс төсөв мөнгө яриад байдаг. Та нарын баталж өгсөн төсвөөр л хийж байгаа. Та нарын өгсөн чиглэлийн дагуу ингэсэн. Бид хиймээр байдаг бараг та нар өөрсдөө ингээд хумиад байна гэсэн ийм агуулгатай зүйлийг буцаагаад тайлбар хийгээд байдаг юм. Тэгэхээр энэ тогтоолд нэг ийм хэнэггүй хандаад байгаа, хайхрамжгүй хандаад байгаа энэ нөхцөл байдал нь ингээд өнөөдрийн тайлангаар ингээд бидэнд орж ирээд байгаа юм л даа. Энийг ганцхан нэг, ганц нэг хувь хүн ч хэлээд байгаа юм биш. Цаашдаа энэ парламент нь парламент шиг, Засгийн газар нь Засгийн газар шиг ажиллах л зайлшгүй шаардлага байгаад байгаа юм. Санал болгож хэлэхэд.

Төрийн албаны зөвлөл яг энэ 9 хувь гэж үнэлэгдсэн энэ үйл ажиллагааны хөтөлбөрийг яг Төрийн албаны зөвлөлийн удирдлагын зүгээс энийг яг юу гэж дүгнэхээр байна вэ? Хэрвээ хэрэгжээгүй бол энэ байр суурь нь өөрөө ямар байр суурьтай гэж үзэх юм бэ? Цаашдаа энэ дээр ер нь ямар бодлого чиглэл гаргаж ажиллах юм бэ гэсэн асуулт л байна даа. Бусдаар асуудал алга.

Ж.Бат-Эрдэнэ: Үг хэллээ. Дараа нь Зулпхар гишүүн. Зулпхар гишүүний микрофоныг нээе.

С.Зулпхар: Та бүхний энэ өдрийн амар амгаланг айлтгая. ТАЗ ээлжит тайлангаа танилцуулж байна. Тайланг би бүрэн уншиж танилцсан, хураангуйтай танилцсан. Их чухал тодорхой үр дүнгүүдийг бидэнд хуваалцаж байгаад талархалтай байна. Би 3 зүйл тодруулж асуух гээд байна. 1 дүгээрт нь төрийн албан хаагчдын сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөр баталж хэрэгжүүлнэ гэсэн ийм бид өөрсдөө зохицуулалттай хууль дээр. Тэгээд тэрийг ингээд л жил болгон тайлан гарахаар зэрэг цөөн тооны байгууллага ийм хөтөлбөр баталсан байдаг, хэрэгжүүлдэг. Гэхдээ хэрэгжүүлэхдээ мэдээж хэрэг нөөц хязгаартай учраас хэрэгжүүлж чаддаггүй гээд. Та бүхэн зөвлөмж өгдөг юм байна. Өгч байгаа угаасаа өгдөг. Энэ дээр сая энэ тайлан дотроос уншихад ер нь цаашдаа нэгдсэн ийм хөтөлбөртэй байх ёстой юм болов уу гэсэн ийм зөвлөмж гарсан байна л даа. Энэ дээр та бүхэн ямар үндэслэлээр ийм байр суурь илэрхийлж байгаа вэ гэдэг нэг ийм асуулт байна.

2 дахь зүйл ер нь өнгөрсөн хугацаанд, ялангуяа ойрын жишээ нь 5 жил бид нэг ийм бэрхшээл учирсан юм. Мэдээлэл технологийн ажилтнуудыг төрийн албанд, ялангуяа төрийн захиргааны жишээ нь албан дээр авах гэхлээр зэрэг их тийм төвөгтэй байдал үүсчихсэн цалин хөлснөөс шалтгаалаад. Тэгээд одоо байгаа та бүхний энэ тайлан дээрээс харахаар зэрэг 728 ажлын байр байх шиг байгаа юм. Тэгсэн тэндээс 150 нь сул, 142 нь мэргэжлийн бус улсууд ажиллаж байна гээд. Үндсэндээ 40 хувь нь огт мэргэжлийн бус, тэгээд энэ хүн байхгүй байна гэсэн ийм дүн гарсан байна. Гэтэл бид чинь нөгөө нэг цахим засаглал цахим шилжилтийг чухал болгочихсон. Бүх л төрийн байгууллагууд дээр чинь шилжилт хийгдээд явж байгаа шүү дээ. И Монголиатай холбоотойгоор, тэрнээс гадна ер нь төрийн албыг аль болох л авлига, хүнд суртлаас ангид байлгах энэ зорилгын хүрээнд. Тэгэхлээр энийг цаашдаа яах ёстой вэ гэдэг дээр та бүхэн ямар байр суурьтай байна вэ? Тэр мэдээлэл технологийн чиглэлийн мэргэжилтнүүдийг төрийн захиргааны албанд авахтай холбоотойгоор дүйцүүлэх гэдэг ч юм уу, эсвэл цалин хөлстэй холбоотой ямар нэгэн санал байна уу гэж байгаа юм.

3 дахь зүйл их тодорхой зүйл асууя. Энэ сонгуулийн жилийн дараа ер нь яах вэ томилгооны зөрчлүүд их гардаг. Харьцангуй 2024 онд харьцангуй бага гарсан юм байна гэж би энэ тоон дээрээс харлаа. Гарахгүй байх ёстой л доо. Хэрвээ ийм зөрчил гарсан байвал энэ дээр ТАЗ яах вэ гэж байгаа юм? Ахлах түшмэлийн албан тушаал дээр ТЗ4 дээр гэж байгаа юм. Энэ бол аймгийн Боловсролын газрын даргын албан тушаал дээр түр орлон гүйцэтгэгчээр л нэг хүнийг томилсон байгаа юм. Тэгээд 1 дүгээрт тэр хүн бол төрийн албанд ажиллах ёстой 6 жилийн шалгуураа хангаагүй байна дэс түшмэлийн. 2 дугаарт дэс түшмэлийн албанд 3-аас доошгүй жил ажилласан байхыг хангаагүй байгаа юм. Ингээд дараагийн 2 дахь зүйл болохоор зэрэг мэргэшүүлэх багц сургалтад хамрагдаагүй гэдэг ийм шалгуур хангаагүй. Тусгай шалгуурууд дотроос магистрын зэрэггүй, төрийн албан хаагчийн ерөнхий шалгалтыг огт өгөөгүй. Ийм нөхцөлд.../минут дуусав/

Ж.Бат-Эрдэнэ: 3 номерын микрофон.

Л.Цэдэвсүрэн: Зулпхар гишүүний асуултад хариулъя. Би эхний 2-т нь хариулъя, манайхан 3 дээр нь бэлдэж байгаарай. Энэ төрийн албан хаагчийн нийгмийн баталгааны хөтөлбөр хуультай юм уг нь. ЗГ яг нэгдсэн журмаар хөтөлбөрөө батлах ёстой улсын хэмжээнд. Гэхдээ яг бид нарыг хяналт шинжилгээ 2024 онд хийхэд энэ хөтөлбөр ЗГ-аас албан ёсоор батлагдаагүй байсан. Тэгвэл батлагдаагүй юм бол төрийн байгууллагууд дээр батлагдсан хөтөлбөрт нь хяналт шинжилгээ үнэлгээ хийж үзье гээд бүх төрийн байгууллагууд руу хандсан боловч манай 44 байгууллага хөтөлбөрийнхөө талаар мэдээлэл ирүүлснээс 35 нь яг өөрийн гэсэн хөтөлбөртэй, бусад нь зүгээр үйл ажиллагааны төлөвлөгөөндөө хүнээ сургана, хөгжүүлнэ баталгааг нь хангана гээд заагаад өгчихсөн. Тэгээд бид ЗГ-т зөвлөмж чиглэлээ өгөхдөө нэгэнт хуультай юм чинь Төрийн албаны хууль дээр байгаа ЗГ яг энийгээ нэгдсэн журмаар нь батлах нь зөв юм байна. Тэгж байж бусад төрийн байгууллагууд дэд хөтөлбөрүүдээ батлахгүй бол хэдийгээр төрийн байгууллага хөтөлбөртэй нь сайшаалтай юм шиг боловч төсөв байхгүй. Төсөв байхгүйгээс болоод энэ хөтөлбөрийн хэрэгжилт туйлын хангалттай биш байдаг юм байна гэж үзсэн.

Тийм учраас бид зөвлөмж энэ тайлан дээрээ ЗГ-аас энэ Төрийн албаны хуулийн 64 дүгээр зүйлд байгаа нэгдсэн хөтөлбөрөө батлаач. Энэ хөтөлбөрөө баталчихвал хамтраад энэний хэрэгжилтийн дагуу бид ажиллая гэдэг ийм

зөвлөмжөө өгөөд явж байгаа. Тэгээд ЗГХЭГ-аас энийгээ батлах судалгааны ажлыг яг өнөөдөр хийгдэж байгаа, манай бүсийн зөвлөгөөнүүдээр давхар хийгээд явж байгаа тэд. Бүх бүсийн зөвлөгөөнд ЗГ-ынхан оролцож, төрийн албан хаагчидтайгаа уулзаж, тэд нарын санаа бодлыг сонсоод явж байна. Сангийн яам, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам хамтраад хийж байгаа.

Дараагийн нэг асуулт нь энэ цахим. Сул орон тоо үнэхээр байна. Яагаад хүн ирдэггүй юм бэ гэхээр албан тушаалын шаардлага хангахгүй гэж байгаа. Тэгээд ЗГ-т бид юу гэсэн хүсэлт тавьчихав гэхээр мэргэжлийн бус хүн гэдэг нь гишүүнээ нөгөө нэг ЗГ нэг тэмдэглэл тогтоол гаргасан шүү дээ сайн хүнийг аваад ажиллуул, тэгээд цалинг нь дабль өг гээд. Энэ ингээд хэрэгжээд явж байсан чинь ЗГ-аас нөгөө үе шаттай төрийн албан хаагчийн цалинг нэмсэн чинь нөгөө нэг илүү их мундаг цалин гэж байсан 3 сая маань одоо илүү цалин биш болчихсон. Энэнээс болоод нөгөө нэг хуучин ажиллаж байсан төрийн үйлчилгээнд ажиллаж байсан хүмүүс нь төрийн захиргаа руугаа орж ирье гэхээр албан тушаалынхаа шаардлагыг хангадаггүй, хуульд заасан шаардлагаа хангадаггүй. Тэгээд нөгөө нэг гэрээгээр ажиллаж байсан өндөр мундаг цалинтай хүмүүс маань өөрсдөө мэргэжлийн бус байх нь аягүй давамгай байсан. Яг нөгөө ИТ чиглэлдээ маш сайн мэргэжчихсэн өөр мэргэжлийн хүмүүс маань нөгөө ЗГ-ын тогтоолын дагуу байгууллагуудад өндөр цалингаар ажиллаж байсан юм байна. Тэгээд буцаагаад нөгөө хэдийгээ ТЗ рүүгээ оруулъя гэхээр 1 дүгээрт мэргэжил нь өөр, 2 дугаарт шаардлагаа хангахгүй. Тэгээд ЗГ-т юу гэсэн зөвлөмж өгсөн бэ гэхээр одоо энэ 3 саяын өндөр цалингаа 1 дүгээрт та нар жоохон өсгө 5 ч юм уу, 6 сая болгох боломж байгаа байх. Тэрний дараа бид.../минут дуусав/

Ж.Бат-Эрдэнэ: 7 номер.

Д.Баатарсайхан: Та бүхэнд оройн мэнд хүргэе. Зулпхар гишүүний асуусан асуултад хариулъя. Тус аймагт томилгооны зөрчилтэй байна гэдэг гомдол ТА3-д ирсэн байгаа. Бид хянан шалгах үйл ажиллагааг Төрийн албаны зөвлөлийн даргын шийдвэрээр маргаан хянан шалгах комисс байгуулаад ажиллаж байгаа. Яг одоогоор зөрчилтэй гэж хэлэх боломжгүй. Яагаад вэ гэхээр холбогдох нотлох баримтуудыг нь татаж ирж байгаа. Ингээд татаж ирээд Төрийн албаны зөвлөлийн хуралдаанаар оруулаад, үнэхээр ажилласан жил нь хүрээгүй, мэргэшүүлэх багц сургалтад хамрагдаагүй байвал 2 янзын үйл ажиллагааны зохицуулалт хийнэ. 1 дүгээрт нь энэ гаргасан шийдвэрээ тодорхой хугацаанд хүчингүй болго гээд хугацаа зааж өгөөд, томилох эрх бүхий албан тушаалтанд нь хүргүүлнэ. 2 дахь нь ТА3 өөрөө хүчингүй болгодог эрхтэй. Шууд ТА3 хүчингүй болгочихъё гэхээр зэрэг нөгөө Захиргааны ерөнхий хуулийн дагуу сонсох ажиллагаа явуулдаг. Тэр үйл ажиллагаа нь томилох эрх бүхий албан тушаалтанд нь илүү байдаг учраас маргаан хянан шалгах журмаар шийдээд явж байгаа гэсэн үг. Түрүүн гишүүний хэлсэн туршлага нь шаардлага хангахгүй, мэргэших сургалтад хамрагдаагүй, дээрээс нь төрийн албаны тусгай байтугай ерөнхий шалгалт өгөөгүй энэ байдал нь нотлогдоод ирвэл энэ зохих арга хэмжээг авна гэж. Баярлалаа.

Ж.Бат-Эрдэнэ: Болсон уу? Батбаатар гишүүн.

Б.Батбаатар: ТА3 өөрөө хуулийн дагуу ажиллаж байгаа, хууль тогтоомжийн хүрээнд ажиллаж байгаа, тайлангаа ч тэгээд ингээд тавих ёстой болохоор тавьж байгаа байх. Тэгэхдээ ийм зүйлийг хэдүүлээ бодмоор байна. Хуульд ийм байгаа учраас хуулийн зөрчил нь энэ байна, энэ дээр болж байна, болохгүй байна гээд

тайлан дүгнэлт гаргахаасаа илүүгээр энэ Монголын төрд хамгийн чадварлаг хүмүүсийг яаж ажиллуулах вэ гэдэг бид нарын уг нь үндсэн зорилго шүү дээ. Тэгэхээр хууль тогтоомжид юу төрд ажиллаж байгаа төрийн албан хаагчид сайн чадварлаг боловсон хүчин ажиллахад саад болоод байгаа зүйлүүд нь юу байгаа юм гэдэг тухай сонсох нь зүйтэй болов уу? Тэр талаар түрүүн нэг хууль 2 салгая гээд ярьж байна гэсэн. Тэр утгаараа юм байгаа юм болов уу гэж ойлголоо.

Тэгвэл төрийн албаны энэ шалгалт бас тодорхой хэмжээнд тухайн мэргэжлээрээ үр дүнтэй сайн ажиллаж чадах тэр боловсон хүчнийг оруулж ирэхгүй хаагаад байгаа зүйл байна уу гэж заримдаа харагдаад байгаа. Төрийн албаны шалгалт ямар агууламжаар явдаг юм бэ? Тухайн мэргэжилд нь зориулж явж байна уу нэг бол ерөнхий нийтлэг Төрийн албаны хууль ч байдаг юм уу эрх зүйн тэр хуулиудын хүрээнд авчихаар зарим салбар дээр тухайн хууль нь гол үйлчлэл биш, мэргэжлийн тухайн мэргэжлийн ур чадварын асуудал илүү чухал байгаад байна шүү дээ. Тэгээд төрийн албаны шалгалтад бэлдсэн хүмүүс нь тухайн салбар мэргэжил дээр бодлогын асуудлууд гаргаж ирэх болохоор чадварлаг инженер, боловсон хүчин, эрдэмтэн мэргэд шиг байж чадахгүй байгаа байхгүй юу. Тэгэхээр тэнд ямар бодлого гарч байна. Тэгэхээр төрийн албаны шалгалтад унаж байна гээд байдаг. Энэ шалгалтад тэнцэж байгаа тэр хүмүүсийн тоо хувь нь бага байна гэж үзээд байдаг. Энэ өөрөө юуг илэрхийлж байгаа вэ гэдэг. Энэ дээр шалгалтын агууламж нь юу байдаг юм, тэр яг мэргэшсэн тухайн салбарынх нь хүмүүсийг илүү тэр тухайн чиглэлдээ бүтээлдээ ажиллаж чадах хүмүүсийг оруулах чиглэлээр юу хийж байгаа юм бэ гэдэг юм байж байна?

3-д нь бид энэ төрийн албыг чадвартай, ёс зүйтэй, шударга байлгаж чадвал тэгээд л бусад зүйл нь засагдах, бусад зүйл нь суралцах, явцын дунд илүү чадавхжих тэр боломжуудыг бүрдүүлэх бүрэн боломжтой шүү дээ. Төрийн албан хаагчдын нийгмийн баталгаа энэ тэр гэж ярихаас гадна тэр бол хууль тогтоомжоор нэгдсэн маягаар шийдэх нь зүйтэй байх. Сайн хүмүүсийг яаж Монголын төрд ажиллуулах вэ гэдэг талаар юуг өөрчилбөл зүгээр байна вэ?

Ж.Бат-Эрдэнэ: 3 номерын микрофон.

Л.Цэдэвсүрэн: Батбаатар гишүүний асуултад хариулъя. Төрийн албаны ерөнхий шалгалт болон тусгай шалгалтын агуулга бол хуульчлагдчихсан. Яах вэ агуулга нь Монгол хэлний, ур чадварын, асуудал шийдэх, дүн шинжилгээ хийх, багаар ажиллах, манлайлах гээд 7 агуулга нь тусгагдчихсан, эрх зүй гээд. Энэний хүрээнд ерөнхий шалгалт дээр яг ямар түвшнийх байх вэ гэдэг нь арай өөр. Тусгай дээр та нэлээн ач холбогдол өгч асууж байна гэж ойлголоо. Тусгай гэдэг нь захиалгат шалгалт гэсэн үг. Тэгэхээр бид яг албан тушаалын тусгай захиалгатай шалгалт дээр Монгол хэл нь тест, хуулийн тест, Монгол хэл, асуудал шийдвэрлэх, дүн шинжилгээ хийх гэдэг хэсэг нь тестийн журмаар явчихдаг. Бусад яг нөгөө хүний ур чадварыг илүү гаргаж ирэх асуудал нь ярилцлагаар явдаг. Ярилцлагаар явахдаа тэр нь хэн нэгний үзэмж болсон ярилцлагын асуултууд биш, онооны хувьд ч гэсэн өөр.

Тэгэхдээ энэ дээр бид юу гэдэг юм шалгалтаа ингээд цахим болгочихлоо, хөндлөнгийн нөлөөлөлгүй болгочихлоо гэж байгаа боловч яг одоогийн шалгалт хэтэрхий хүний нөгөө зөвхөн мэдлэгийг шалгасан шалгалт болоод байгаа гэдэг дээр бид өөрсдөдөө шүүмжлэлтэй хандаж байгаа. Одоо юу хийж эхэлж байна вэ гэхээр ур чадварын үнэлгээг нь тогтоогоод, мэдлэгээс гадна тэр хүний хандлага,

ёс зүй, ур чадвар, санаачилга, идэвх юу байна кэйс ажиллуулж тэр хүнийг бүрэн илэрхийлж гарах хэмжээний хүртэл тестийн сангийн баяжилтыг хийж эхэлж байна. Тэгэхээр энэний дагуу бид шалгаруулалтаа хийгээд явчихвал таны хэлж байгаа асуудлууд нэлээн цэгцэрнэ гэж үзэж байгаа.

Нөгөөтээгүүр Монгол Улсын төрд шударга, ийм сайн хүн ажиллах ёстой гэдэг дээр тантай санал нийлж байгаа. Тийм учраас бид энэ ур чадварын хүрээ гэдэг зүйлийг нэлээн сайн гаргаж ирж, төрийн албан хаагчдаа үнэлж байж цаашаа шат ахиж явах нь зөв юм байна гэж үзэж байна. Манайхан нэмэхээр зүйл байвал нэмж болно.

Ж.Бат-Эрдэнэ: Болно. Батбаатар гишүүн тодруулъя.

Б.Батбаатар: ЗГ-ын 14 мега төсөл, Улаанбаатар хотын 24 мега төсөл гээд байж байгаа шүү дээ. Энэ чиглэлээр чинь жишээ нь ний нуугүй хэлэхэд энэ том төслүүдийг хөдөлгөх хэмжээнд тэр ТЭЗҮ-г, тэр ТЭЗҮ битгий хэл хөрөнгө оруулалт болон тухайн төслийг хэрэгжүүлэх тэр хэлэлцээрийг хийхэд нөгөө төрийн албан хаагч чинь хэрэг болно шүү дээ. Тэгэхээр ТАЗ жишээ нь энэ том төслүүд дээр ажиллах тэр төрийн алба хаах тэр хүмүүсийг, хүмүүсээс асуух асуулт энэ ерөнхий шалгалт юм уу, тусгай шалгалт дээр чинь унаад байна лээ гэхэд тэр хэмжээний тэр боловсон хүчнийг оруулж ирэх тал дээр бодож байгаа зүйлүүд байгаа юу? ЗГ Монголын Шинэ сэргэлтийн бодлого гээд мөрийн хөтөлбөрөөр 14 мега төсөл хэрэгжүүлнэ гэхихсэн байна. Энэ тал дээр зөвлөмж боловсруулж ажиллаж байгаа зүйл байгаа юу гэдэг?

Ж.Бат-Эрдэнэ: Хариулъя, хариулт өгье, 3 номер.

Л.Цэдэвсүрэн: ЗГХЭГ луу 2 ч удаагийн зөвлөмж явуулсан. Яагаад явуулж байгаа юм бэ гэхээр бид энэ юу гэдэг юм захиалгат шалгалтуудыг ингээд аваад яагаад ингээд 40 хэдхэн хувьтай яваад байгаа юм, 45-хан хувьтай. Яах вэ ноднинг бодвол тодорхой хэмжээгээр нэмэгдсэн л дээ хувь нь. Гэхдээ 45 хувь гэдэг хангалтгүй, 100 хувь байх ёстой л доо. Тэгээд нөхцөл байдал юун дээр болоод байгаа юм бэ гэхээр албан тушаалын тавигдаж байгаа шаардлагыг бид цэгцлэх тал дээр нь нэлээн ажиллаж байгаа юм. Хэтэрхий өндөр шаардлага, хэтэрхий өндөр мэргэжлийн индексүүд, хэтэрхий цөөхөн хүнд зориулсан мэргэжлийн индексүүдийг 2024 оноос хумьж эхэлсэн. Аль болохоор нээлттэй байлгах, аль болохоор олон хүн өрсөлдөх зорилгоор. Нөгөөтээгүүр зөвхөн төрийн захиргааны албанд ажиллаж байгаа хэдэн хүн тойргийн журмаар ингээд албан тушаал хашаад байхаасаа илүүтэй төрийн үйлчилгээнд ажиллаж байгаа мэргэжилтэн, судлаач мундаг хүмүүсийг ажилд дээш нь карьерын зарчмаар.../минут дуусав/

Ж.Бат-Эрдэнэ: 3 номерыг дахиад сунгая.

Л.Цэдэвсүрэн: Төрийн үйлчилгээний алба хашиж байсан албыг нь төрийн захиргааны албатай дүйцүүлэх ажлуудыг нэлээн хийж байна. Ингэснээрээ бид магадгүй юу гэдэг юм төрийн үйлчилгээнд ажиллаж байгаа маш сайн мэргэжилтнүүдийг дээшээ ТЗ рүү татаж чадаж байна л даа. Нөгөө талаасаа улс төрийн албан тушаалд ажиллаж байсан сайн мундаг хүмүүс байна. Эд нарыг буцаагаад төрийн захиргаа руу хөрвүүлэх адилтгах асуудлыг 24 онд нэлээн хийлээ. Ингэснээрээ нөгөө зөвхөн ТЗ дээр ажиллаад ингээд хаашаа ч хөдөлдөггүй байсан албыг ТҮ, ТТ, улс төрөөс нь ингээд холимог болгож цэгцлэх ажлыг

хийснээрээ энэ 14 мега төсөл дээр бид нэлээн гайгүй боловсон хүчнүүдийг бэлдэж чадна л гэж бодож байгаа.

Ж.Бат-Эрдэнэ: Болсон уу? Би ганц, хоёр асуулт асуугаадахъя. ТА3 маань тайлангаа явуулж байгаа Улсын Их Хуралд. Өөрөөр хэлбэл ТББХ ингээд хэлэлцээд дүгнэлт гаргаж байгаа, хэлэлцэж байгаа, сонсож байгаа. Хэд хэдэн асуулт байна л даа. Жишээ нь Төрийн албаны зөвлөлийн гишүүн 5 гишүүн ажиллаж байгаа. Их Хурлаас, Засгийн газраас, Ерөнхийлөгчөөс, төрийн албан хаагчдаасаа гээд. Та 5 ер нь хэр ажиллаж байгаа гэсэн дүгнэлт хаанаас гарах вэ? Тайлан дээрээ байх юм уу, хэрхэн ажиллаж байна, яаж шалгуулмаар байна вэ? Шалгуулах юм уу эсвэл энэ өмнөх үгэн дээр заасанчлан бие даасан, хараат бусаар ажиллаж байна гээд ингээд ажиллаж байгаа юу?

2 дугаарт өнөөдөр тайлан тавьж байна. Тайлангаа мэдээж төлөвлөгөө гэж байгаа биз. Тэрнийхээ хүрээнд өнөөдрийн тайлан тавьж байна. Энэ тайлангаа та батлаад явж байгаа юу? Өөрөөр хэлбэл нөгөө төлөвлөгөөгөө энэ бас сонирхол татаж байгаа.

3 дугаарт нэн тэргүүнд би сая хэллээ шүү дээ. Энэ байгууллагын өөрийнх нь яг үйл ажиллагаа дээр үнэлэлт дүгнэлтийг бид яаж өгөх юм бэ? Хууль дээр тийм юм байхгүй байгаа л даа. Нэгэнт бид сонсож байгаа бол энэ олон гишүүдээс гарч байгаа санаа оноо хэрхэн хэрэгжиж байгаа вэ, амьдрал дээр ямар алдаа дутагдлууд гарч байгаа гээд энэ зүйлүүдийг бид буцаад нэг, буцаад тунгаагаад үздэг хардаг, энэ дээр нь үүрэг даалгавар, чиглэл өгөөд ингээд явдаг нэг ийм зарчим байх ёстой. ТА3 мерит зарчим баримтална гэж байгаа. Одоо ажил руугаа ороодохъё. Энэ мерит зарчим маань яг хэр баримтлагдаж байгаа вэ? Төрийн албаны албан хаагчдын боловсрол, мэдлэг боловсрол нөгөө тавигдах шаардлагууд ер нь хэр хангагдаж явж байгаа гэж үзэж байгаа вэ гээд энэ нэг хэдэн асуултад л хариулж өгөөч.

Бас ийм байна. 4 удаагийн шалгалт авч байгаа гэж байгаа юм. Энэ чинь өөрөө зөв юм уу? Яг ингэж та нар яг юу гэж үзэж байгаа юм бэ? Эсвэл 1 ч бай, 2 ч бай шууд онлайнаар юмаа бөглөлөө, шалгалт аваад ингээд явж болохгүй юу? Заавал улирал болгонд ч байдаг юм уу ингээд нэг удаа шалгалт авдаг чинь яг зөв юм уу? Энэний чинь үр дүн, сайн тал, зөв тал, сөрөг тал гэсэн ийм юм 2 талтай байх ёстой шүү дээ, байгаа шүү дээ, тэрийгээ хариулж өгөөч. Тийм хэрэгцээ байна уу, зайлшгүй юм уу 4 байх нь? Энэ хэдэн асуултад хариулж өгөөч. 3 номер.

Л.Цэдэвсүрэн: Байнгын хорооны даргын асуултын 1, 2, 5-д нь би хариулъя. 2. 3-д нь манай гишүүд бэлдэж байгаарай. ТА3 өөрөө хамтын зарчмаар шийдвэр гаргадаг ийм байгууллага. Хамтын зарчим гэдэг нь ерөөсөө дандаа зөвлөлийн хурлаараа асуудлаа шийддэг, хэн нэгэн хүн дарга нь ч юм уу, гишүүн нь тусдаа ганцаараа хэзээ ч шийдвэр гаргадаггүй, ямар ч асуудал дээр нэг дэх нь.

2 дахь нь минийхээр энэ Улсын Их Хурлын Тамгын газар манай үйл ажиллагааг дүгнэдэг. Улсын Их Хурлын Тамгын газар Улсын Их Хурлын Хяналт шалгалтын газар нь манай байгууллагын үйл ажиллагааг дүгнэж үнэлгээ өгдөг. Тэр үнэлгээг манай тайланг аваад яаж үнэлж, яаж үнэлснийг нь би мэдэхгүй байна, дүгнэснийг нь. Бидэнд тэр бол албан ёсоор ирээгүй байгаа. Тэгээд бидний ажлыг үнэлж дүгнэдэг газар нь Улсын Их Хурал, Тамгын газар, Байнгын хороо. Бид өөрөө өөрсдийнхөө ажлыг дүгнэдэггүй. Аливаа нэгэн шийдвэрийг хамтын зарчмаар буюу

Төрийн албаны зөвлөлийн хуралдаанаараа дандаа хэлэлцэж шийдвэрлэдэг. Энэ нь энэ байгууллагын эцсийн шийдвэр болдог. Тухайн манай байгууллагын төлөвлөгөө, үйл ажиллагааны стратеги, тайлан бүгдийг нь Зөвлөлийн хурлаараа хэлэлцэж баталдаг Зөвлөлийн хурлаараа. Одоо 24 оны, 25 оны төлөвлөгөөнүүдийг бүгдийг нь Зөвлөлийн хурлаараа хэд хэдэн удаа хэлэлцэж, яг албан ёсоор баталгаажуулсан. 24 оныхоо тайланг мөн Зөвлөлийн хурлаараа хэлэлцээд, яг ийм тайлан гаргалаа, энийг ингэлээ гэдэг дүгнэлтүүдийг гаргаад явж байгаа.

5 дахь асуултын хувьд миний өөрийнх нь хувьд, миний хувьд энэ ерөнхий шалгалтыг жилд 4 удаа авдаг нь буруу. Хэтэрхий их нөөц хийчхээд, бид хүмүүст нөөцийн хэрэгжилтээ төдийлөн сайн хангаж чадахгүй байгаа. Нөөцөд бүртгэгдсэн хүний тоо нь энд их, нөгөө төрийн албанд орох гэж байгаа сул орон тоо хоёрынх нь баланс нь барихгүй. Энд ингээд сул орон тоо нь цөөхөн, энд нөөцийн хүмүүс байгаад байдаг. Сүүлийн 3 жилийн судалгааг аваад үзсэн чинь манай ерөнхий шалгалтын нөөцөд бүртгэгдсэн хүмүүсээс хувийн хэвшил рүү маш их орсон. Хувийн хэвшлийн бүр зарим байгууллагууд дээр Төрийн албаны зөвлөлийн ерөнхий шалгалтад 80-аас дээш оноо авсан байвал тэр нь давуу байдал болно гээд байж байдаг юм байна. Тэгэхээр бид яах вэ нэг талдаа төрийн албаныхаа нөөцийг бүрдүүлэх нь зөв боловч нөгөө талдаа Монгол Улсынхаа хүний нөөцийг бүрдүүлэхэд хувь нэмрээ оруулаад байгаа юм шиг харагдаад байгаа юм.

Энэ ерөнхий шалгалт өгч байгаа хүмүүсээс судалгаа авч үзсэн. Та ер нь яах гээд ерөнхий шалгалт өгөөд байгаа юм бэ гээд. Тэгээд яах вэ дийлэнх хувь нь 50 гаруй хувь нь Монгол Улсын төрийн албандаа ажиллая гэсэн чин хүсэл эрмэлзэл байна гэж байгаа юм. 30 гаруй хувь нь болохоор би зүгээр өөрийгөө сорьж үзсэн юм би одоохондоо хувийн хэвшилд байгаа. Танай энэ нөөц чинь 3 жил юм чинь магадгүй би 3 дахь жилээ дуусахын өмнөхөн төрийн алба руу орох орж болох юм гэдэг. Тэгэхээр нөөцийн хугацаа 3 жил байдаг нь нэг талдаа асуудал юм болов уу гэж харж байгаа. Бид Солонгосыг нэлээн судалж байна. Тэдний нөөцийн хугацаа нэг жил. Тэгээд тэд хэзээ нөөцөө бүрдүүлдэг юм гэхээр төрийн байгууллагууд захиалга өгсөн тохиолдол болгонд нөөцийн хугацаа.../минут дуусав/

Ж.Бат-Эрдэнэ: Хариулт болсон уу? 6 номер.

Б.Пүрэвдагва: Оройн мэнд хүргэе. Бат-Эрдэнэ гишүүний асуултад нэмж хариулъя. 1 дүгээрт нь ТАЗ-өөс энэ мерит зарчим хэр хэрэгжиж, баримталж байгаад 2 үндсэн арга хэлбэрээр төрийн байгууллагуудыг үйл ажиллагаанд нь нь хүний нөөцийн аудит болон хяналт шалгалтын журмаар энэ 2 хэлбэрээр мерит зарчим хэрэгжиж байгаа дээр үнэлэлт дүгнэлт өгдөг. Анх ТАЗ анх чадавхын зарчмын хэрэгжилт сэдвээр Эрчим хүчний яаманд хийсэн. Энэ хүрээндээ тухайн албан тушаалын тодорхойлолтод тавигдаж байгаа боловсрол, мэргэжил, туршлагын шаардлага, мэргэшсэн байдалд нь бид албан тушаалын тодорхойлолт дээр нийцэж байгаа байдалд нь хүний нөөцийн аудитын үнэлгээ хийж байгаа. Мөн төрийн жинхэнэ албан хаагчийг сонгон шалгаруулах, томилох үйл ажиллагаанд хяналт шалгалт хийсэн. Өнгөрсөн 2024 оны болохоор 499 байгууллагын 10 мянга гаруй төрийн албан хаагч нарт хяналт шалгалт хийснээс зөрчилтэй 465 гэдэг нь болохоор өөрөөр хэлбэл эд нар бол албан тушаалын тодорхойлолтод тавигдсан боловсрол, мэргэжил, мэргэжлийн шаардлага, туршлагын шаардлагыг хангаагүй гэдэг үндэслэлээр нь зөрчилтэй томилгоо гэж гараад, ТАЗ-өөс мэдээж хяналт

шалгалтынхаа хүрээнд зөрчлийг нь тогтоогоод, тодорхой хугацаатай үүрэг даалгавар өгч, биелүүлээгүй тохиолдолд шийдвэрийг нь хүчингүй болгодог.

Хүний нөөцийн аудитын хүрээнд болохоор манайхаас тухайн байгууллагад аудит хийгээд, зөвлөмжүүдээ өгдөг. Энэ хүний мэргэжил нь таарахгүй байна, мэргэжил нь таарахгүй байна, туршлага нь таарахгүй байна энэ нийцлийгээ хангахыг. Мөн чадавхын зарчмынхаа хүрээнд тухайн төрийн байгууллагад ажиллаж байгаа төрийн албан хаагчид нь хуулийнхаа дагуу шатлан дэвших журмынхаа дагуу энэ хүнийг шатлан дэвшүүлж байна уу гэх мэтчилний арга хэлбэрээр бид энэ мерит зарчмын хэрэгжилт нь хэр баримталж хэрэгжиж байгаа дээр нь үнэлгээ дүгнэлт, хяналт шалгалтын ажил хийгддэг.

Ж.Бат-Эрдэнэ: Болсон уу? Энэ төрийн албан хаагчдын боловсрол яг ямар хэмжээнд явж байгаа вэ? Үнэхээр та бүхний гарч байгаа хүрээнд дүгнэлтийн хүрээнд боловсрол, мэдлэг, чадвар нь хэр явж байна гэсэн ямар дүгнэлт гарсан түүн дээр асуулт асуусан даа. Юу гэж үзэж байгаа юм бэ? Хэн хариулах уу? 6 номер.

Б.Пүрэвдагва: Бат-Эрдэнэ гишүүний асуултад хариулъя. Ер нь хууль дээр Төрийн албаны тухай хууль дээр төрийн албанд тавигдах шаардлага тавигдчихсан байгаа. Энэ дээр төрийн албан хаагчид дээд боловсролтой байх шаардлагууд тавигдсан. Дээд боловсролынх нь хүрээнд нь яаж байгаа, мэргэжлийг нь шалгачхаж байгаа. Гэхдээ ТАЗ-өөс хүний нөөцийн аудит хийхэд ур чадварыг нь хэрхэн яаж хүрээг нь нөгөө цогц чадамжийнх нь хүрээ нь ямар түвшинд байх вэ гэдгийг нь болохоор тогтооход хүндрэлтэй байгаа.

Ж.Бат-Эрдэнэ: Үгүй ээ үгүй. Энэ ямар түвшинд байгаа вэ? Ер нь яг ийм шаардлагаа хангаж чадаж байгаа юу, чадахгүй байна уу, сайжруулах ёстой юм уу, яг ямар түвшинд явж байна вэ? 3 номер.

Л.Цэдэвсүрэн: Өнөөдөр 2024 оны 12 сарын 31-ний байдлаар Монгол Улсад ажиллаж байгаа нийт төрийн албан хаагчдын бараг 79 хувь нь бакалаврын буюу дээд түвшинд дээд боловсрол эзэмшсэн хүмүүс байгаа. Энэ бол шаардлагаа хангаж байгаа гэсэн үг. Яагаад гэхээр хуулийн анхдагч нь төрийн албанд ялангуяа захиргааны төрийн жинхэнэ албанд ороход заавал дээд боловсролтой байх шаардлага тавьж байгаа. Төрийн үйлчилгээнд ажиллах тодорхой албан тушаалууд дээр мэдээж мэргэжлийн болон бакалаврын, дэд бакалаврын ч юм уу ийм мэргэжил шаардаж байгаа. Энэ нь ихэвчлэн хаана шаардаад байна гэхээр туслах албан тушаалтнууд, туслах статустай албан тушаалууд дээр энэ нь тавигдаад байгаа юм. Тэрнээс биш яг юу гэдэг юм төрийн үйлчилгээний удирдах, төрийн үйлчилгээний холбогдох түвшний албан тушаалууд, төрийн захиргаа, төрийн жинхэнэ, улс төрийн албан тушаалтнуудад тавигдаж байгаа хамгийн доод түвшин бол дээд боловсролтой байх ёстой гээд хуультай. Тэгэхээр энийгээ бол хангаж байгаа гэж үзэж байгаа.

Ж.Бат-Эрдэнэ: Монгол Улсын төрийн алба маань сайн явж байгаа гэж дүгнэж байна тийм ээ? Энэ төрийн албаны нөөц, шаардлага хэрэгцээ 2 чинь бүүр харилцан адилгүй байна гээд байна шүү дээ. Тэгээд энэ дээр чинь та нар энэ нь харилцан адилгүй байгаа гээд энэ төрийн албаны чинь асуудал доголдож байна л гэсэн үг биз дээ? Зөв үү, буруу? Энэ яг яах ёстой юм, яаж энийгээ өөрчлөх ёстой юм бэ? Та сая хэллээ шүү дээ өөрөө. 3 номер.

Л.Цэдэвсүрэн: Ерөнхий шалгалт өгөөд нөөцөд бүртгэгдсэн хүмүүс гэдэг маань зөвхөн нөгөө их, дээд сургууль төгсөөд, ерөнхий шалгалт өгч байгаа хүмүүс би нөөц маань. Төрийн албандаа ажиллаж байгаад өвдсөн, төрийн албандаа ажиллаж байгаад урт хугацааны сургалтад явсан хүмүүс бүгд нөөцөд бүртгэгдэж байгаа. Юу нь болохгүй байна гэхээр сул орон тооны захиалга нөгөө нөөцөд бүртгэгдсэн хүмүүсийн балансын харьцаа арай л хэтэрхий зөрөөтэй байгаад байна. Тэгээд бид яагаад энэ нөөцөд бүртгэгдсэн хүмүүсийгээ төрийн алба руу их авахгүй байгаа юм бэ, ажилд авахгүй байгаа юм бэ гээд судалгаа хийгээд үзсэн ноднин. Тэгэхээр энэ яам, агентлаг, ялангуяа төрийн захиргааныхны ажлын байрны нэршил дээр асуудал эхлээд гарч ирсэн. Дандаа ахлах мэргэжилтэн, шинжээч, ахлах шинжээч, референт, ахлах референт гээд. Тэрнийх нь болзол, шаардлагыг хангадаг хүмүүс нь нөгөө ерөнхий шалгалт өгөөд, нөөцөд бүртгэгдчихсэн хүмүүс маань дийлэнх нь хангадаггүй. Тийм учраас бид яам, агентлаг, аймгийн Засаг дарга нартай юу гэсэн ажил зохион байгуулсан юм гэхээр туслах болон мэргэжилтний.../минут дуусав/

Ж.Бат-Эрдэнэ: Харин тэгээд наадхыг чинь л засах гэж та 5 маань сууж байгаа юм биш үү? Засаж байна. Алив наадхаа микрофондоо хэл дээ, 3 номер.

Л.Цэдэвсүрэн: Нөөцийн ашиглалт 2023 онд чинь 35 хувьтай байсан. 35-хан хувьтай. Тэгээд бүр гайхаад яагаад энэ болдоггүй юм бол гээд. Тэгээд түрүүний хэлсэн ажлуудыг хэрэгжүүлсний үр дүнд энийг бид 45,7 хувь руу татаж чадсан. Яагаад татсан юм гэхээр ажлын байруудыг нь зөв болгож чадсанаар энийг хийж байгаа.

Ж.Бат-Эрдэнэ: Одоо хэдэн хувь руу очих ёстой вэ?

Л.Цэдэвсүрэн: Одоо энийг ингээд бидний санаа бол 70, 80, 90 хувь руу аваачмаар байна. Гэхдээ төрийн байгууллагуудын нөгөө албан тушаалын нэршлээ баталдаг эрх нь тэд нарт байгаа учраас бид дандаа зөвлөж, энийг залруулж хийлгэж байгаа. Буцаагаад нөгөө талдаа бид энийг юугаар хийсэн гэхээр албан тушаалын тодорхойлолтыг нь батлах зөвшөөрөл өгөхдөө бүх алдаануудыг нь засуулж энийг хийж чадсан.

Ж.Бат-Эрдэнэ: Төрийн алба зөвлөмжөөр явахгүй. Та хэд ч гэсэн.../үг тасрав/

Л.Цэдэвсүрэн: Хууль нь тийм.

Ж.Бат-Эрдэнэ: Үгүй ээ тэгээд засъя л даа наадхаа. Та хэд ч гэсэн томилогдсон хүмүүс шүү дээ. Сонсгол хийж байгаад томилогдсон хүмүүс, сонгогдсон биш, томилогдсон хүмүүс. Тийм болохоор би ингээд хатуу юм нэхээд байна шүү дээ та нараас. Тэр утгаараа цаана чинь төрийн алба гэдэг хатуу алба байж байна. Тийм болохоор тэр хүмүүст зөвлөмж байх ёсгүй. Зөвлөмж битгий хэл удирдамж байх ёстой. Заавал биелүүлэх удирдамж байх ёстой шүү дээ. Гишүүд асуулт асууж дууслаа. Үг хэлэх гишүүд байна уу? Нэрсээ өгье. Зулпхар гишүүнээр, миний нэрийг тавьчхаарай, тэгээд Зулпхар гишүүнээр тасаллаа. Зулпхар гишүүний микрофон өгье.

С.Зулпхар: Их тодорхой мэдээ сонслоо. Асуултад их тодорхой хариултууд ч авч байна. Би асуусан асуулттайгаа холбогдуулаад санал хэлнэ л дээ. 1 дүгээрт сая Цэдэвсүрэн даргын хэлдэг зөв л дөө. Улсын хэмжээнд бид нэгдсэн нэг хөтөлбөр батлаад, хэрэгжүүлэх ёстой, тэр маань байхгүй гэж. Тэр үнэн. Байхгүй учраас байгууллагууд өөрсдөө батлаад хэрэгжүүлж байгаа нь үнэн. Гэхдээ тэр хөтөлбөр байгаа боловч хөтөлбөрт нь тохирсон нөөц байхгүй нь бас үнэн. Тэгэхлээр энэ бол эцсийн дүндээ ямар нэгэн байдлаар нэгдсэн хөтөлбөр байж таарах байх. Салангид шийдвэрүүд байгаа. ЗГ-ын тогтоол гараад бид цалин хөлсний бодлогыг нэлээн ахиулчихсан та бүхэн мэдэж байгаа байх. Өнгөрсөн хугацаанд 3 том шийдвэр гарсан. Тэрний үр дүнгээр өнөөдөр төрийн албан хаагчдын цалин хувийн хэвшлийн ижил, адилтгах албан тушаалтай ажилтай харьцуулбал 23 хувь доогуур байсан бол одоо 6 хувь доогуур ийм сайн үр дүн гарч байна гэсэн үг юм. Тэгэхээр энэ бол нэгдсэн шийдвэр ямар үр дүнд хүргэдэг вэ гэдгийг харуулж байна гэсэн үг.

Дараагийн зүйл одоо энэнтэй уялдсан байдлаар сая манай Байнгын хорооны дарга ч гэсэн асууж байна. Энэ сургалт, хөгжлийн бодлого яах юм, тэр нөгөө нэг нийгмийн баталгааны бодлогоо нь яах юм гэж. Нийгмийн баталгааны бодлого дотор бол ялангуяа орон сууцын бодлого байгаа юм. Энэ бол үнэхээрийн хангалтгүй байгаа шүү дээ. Үндсэндээ 20 жоохон гаруй хувьтай хамрагдсан, сүүлийн судалгаанаас 70 хувь нь бид ерөөсөө энэ чиглэлийн хөтөлбөр дэмжлэг аваагүй гэдэг ийм байдалтай байгаа. Энэ бол өөрөө төрийн албан хаагчдын тогтвор суурьшилд, цаашлаад төрийн албаны жишээ нь чадамжид нөлөөлөх учраас энэ дээр та бүхний өгсөн зөвлөмж цаашдаа төрийн бодлогод тусах ёстой байх. Энэ дээр та бүхэн анхаараарай.

Сая даргын асуусанчлан төрийн албан хаагчдын сургалт, хөгжлийн асуудал яах юм бэ гээд асуулт гарч ирээд байна. Тэр үнэн. Тэгэхээр дээр 3 зүйлийг бид эндээс тогтоол, би хурал дээр зориуд тэмдэглүүлмээр байна. Төрийн албан хаагчдын сургалт, хөгжлийн асуудал бол 3 зүйлээс шалтгаална. 1 дүгээрт шалгалт өгч байгаа хүн, төрийн албанд орох гэж байгаа хүн бол өөрийгөө бэлдсэн байх ёстой. Тэгж байж төрийн албанд нөгөө сонгон шалгаруулалтад ордог. Энэ бол тэгээд нөгөө сонгон шалгаруулалтаараа ерөнхий шалгалтаар гараад ирдэг юм шүү дээ ерөнхий болон тусгай шалгалтаар. Гэхдээ энэ бол хангалттай биш. Тодорхой ажил дээр очсон нөхцөлд дараагийн жишээ нь сургалтууд явдаг. Тэр нь сургалтын байгууллагаар явдаг. Гэхдээ сургалтын байгууллага өнөөдөр хангалттай энэ сургалтыг хэрэгжүүлэх хэмжээний өргөн хүрээнд сургалт явж чадахгүй байгаа бол энийг бид сургалтын хөтөлбөрийн, сургалтын үндсэн төлөвлөгөөг нь дахиж харах байдлаар энэ дээр анхаарал хандуулах цаг нь болчихсон юм шиг байгаа юм. Бид мэргэшүүлэх сургалтууд байгаа, дунд хугацааны сургалтууд байгаа, тэр битгий хэл богино хугацааны сургалтуудыг өргөжүүлэх байдлаар энийг бол хийх чиглэл рүү орох ёстой байх. Сургалтын хэлбэрүүд нь цахим хэлбэрээр байж болно, зайн хэлбэрээр байж болно, ажлын байран дээр байж болно энэ дээр анхаарах ёстой.

Энэнтэй уялдсан байдлаар 3 дахь зүйл. Байгууллага өөрөө хүнээ бас бэлтгэж авна. Ажилд авсан хүнээ тухайн ажилд нь мэргэшүүлэх чиглэлээр ажилладаг олон улсын туршлага байгаа. Энэ талаас нь ингээд ажиллана, тэгээд яг энийг дагалдсан байдлаар тухайн ажилд очсон хүн бол өөрийгөө цааш нь хөгжүүлээд явна шүү дээ энэ чинь төрийн ажил юм чинь. Хэн нэгэн ирээд тэр хүнийг их агуу их төрийн албан хаагч болгохгүй нь ойлгомжтой учраас. Энэ дээр

та бүхний хийж байгаа ажил их чухал байгаа. Би бол энийг сайшааж байгаа гэдгийг хэлмээр байна.

2 дахь зүйл миний нөгөө асуулттай холбоотой. Тэртээ тэргүй бид нөгөө тодорхой жишээ нь мэргэшсэн ажилтнуудыг гэрээгээр ажил гүйцэтгүүлэх байдлаар авдаг энэ олон улсын жишиг байгаа юм. Тэгэхлээр энэ рүүгээ ер нь орохгүй бол зарим ажил дээр бид хүн олохоо байх юм байна лээ. Яг хөдөлмөрийн зах зээл чинь өөрөө хязгаартай хүний нөөцтэй учраас энэ дээр бид цаашдаа ингээд шинээр зохицуулалт хийж таарах байх. Одоо байгаа зохицуулалтаараа явна гэхлээр зэрэг бэрхшээл үүсдэг. Тэгээд хүн ирээгүй учраас сайн хүн байхгүй, маргааш бид энийг хэрэгжүүлж чадаагүй эсхүл хэрэгжүүлэхэд бэрхшээл үүсэж байна гэдэг тайлбар тавьж болохгүй учраас саяын таны хэлсэнчлэн нэг бол дүйцүүл, нэг бол жишээ нь өндөр хэмжээний цалинг нь амласан байдлаар гэрээгээр ажиллуулдаг энэ зохицуулалт руу орж таарах нь гэдгийг хэлье. Энэ зөвхөн мэдээлэл технологийн ажилтнууд дээр биш шүү дээ. Төсөл хэрэгжүүлэх дээр ч гэсэн адилхан. Төслийг чинь маш өндөр түвшний төсөл удирддаг улсууд хэрэгжүүлдэг байхгүй юу. Тэгэхээр энэ дээр бол.../минут дуусав/

Ж.Бат-Эрдэнэ: Зулпхар гишүүнд 1 минут өгье.

С.Зулпхар: Дараагийн зүйл бол мэдээж хэрэг та бүхэн маш сайн хяналт шалгалт хийж байгаа. Маргаан үүсдэг маргааныг хянан шалгаж байгаа. Гэхдээ их тодорхой зүйл дээр эхнээс нь тодорхой байх ёстой гэдгийг энэ хүн томилж байгаа улсууд л өөрсдөө мэдмээр байгаа юм. Энэ бол Төрийн албаны зөвлөлийн буруу биш, төрийн албаны салбар зөвлөлийн буруу ч биш. Ер нь тэгээд л сонгуулийн дараа ямар нэгэн ажил дээр очсон хүн хэн нэгнийг явах ёстой гэж бодоод тавьчих гээд байдаг хөөрхий дараа нь энэ нь алдаа болдог. Алдаа нь өөр дээр нь хүнд тусаж байгаа шүү дээ. Энийг сайн ойлгомоор юм шиг байгаа юм. Тэгээгүйгээсээ болоод удахгүй шүүх дээр очоод л нөгөө хүнийхээ цалин хөлснөөс авхуулаад л бүх юмыг төлдөг ийм байдал руу орох байх гэсэн ийм бодолтой байна.

Төгсгөлд нь би ТАЗ зохих түвшинд ажлаа хийж байгаа гэдгийг хэлмээр байна. Харин бид Төрийн албаныхаа зөвлөлийг Улсын Их Хурлаас нэгэнтээ бид гишүүдийн томилдог байгууллага институт учраас бие даасан болон хараат бус, тогтвортой, тэрнээс гадна мэргэшсэн түвшинд ажиллах түвшинд нь бид дэмжлэг үзүүлээд явах ёстой гэж бодож байгаа юм. Энэ чиглэлээр бид.../минут дуусав/

Ж.Бат-Эрдэнэ: 2024 оны Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны тайлан гээд энэ их том тайлан гарсан байгаа. Тэгээд энд энэний хүрээнд энэ их том тайлан байна шүү дээ. Энэний хүрээнд хийсэн ажлууд сая бүүр 20 гаруй минутад өөрөө танилцуулга хийгээд Цэдэвсүрэн дарга багтсангүй. Мэдээж энэ бол ярихад нэлээн олон зүйл болно. Би юу хүсээд байна гэхээр та бүхнийг эндээс ерөнхийдөө Улсын Их Хурлаас томилоод явуулж байгаа юм. Энэ хугацаандаа ямар нэгэн удирдамж, одоо би асуугаад байгаа шүү дээ, тэр төлөвлөгөө юмнуудаа та нар яаж баталдаг вэ гэхээр чинь 5-уулаа ярьж байгаад л хоорондоосоо хамтын шийдвэрээр батлаад явчхаад байна шүү дээ. Тэгэхээр энэ баталж байгаа төлөвлөгөө дотор чинь тодорхой хэмжээний Улсын Их Хурал, Засгийн газрын тодорхой бодлогууд шингэсэн байх ёстой. Тэгж байж энэ төлөвлөгөө батлагдаад, энэ төлөвлөгөөнийхөө дагуу энэ тайлан чинь гарч ирчхэж байгаа байхгүй юу даа.

Миний хүсээд байгаа зүйл юу байна гэхээр эндээс тодорхой хэмжээний зөвлөмжүүд гарч байх ёстой. Хяналт шалгалтын, Тамгын газар байна уу, ямар хяналт шалгалтын нөгөө юуны хөндлөнгийн аудит ч байна уу ийм зүйлүүдээр гаргаж ирээд, та бүхний хийж байгаа ажил дээр зөвлөмжүүд гаргаад, энэ чинь бас тодорхой хэмжээний саналууд орж ирж байгаа шүү дээ. Энэ саналуудтай чинь уялдаад ийм, ийм бидний хувьд төрийн байгуулалт болоод Улсын Их Хурал хийх ёстой тэр хуулийг болон бусад дүрэм журмын хүрээнд өөрчлөлт хийх ёстой асуудал дээр эргэж харах, тэр тусмаа хууль дээр. Та нарын хүрээнд хийж байгаа ажлаа 2024 онд хийсэн ажлууд дээр чинь илүү сайжруулах, сая миний асуугаад байгаа асуудал байна шүү дээ. Ерөнхийдөө Монгол Улсын төрийн албан хаагчдын мэдлэг боловсролын түвшин яг ямар хэмжээнд явж байгаа юм, та нар юу гэж үзээд байгаа юм, мерит зарчмаар энэ чинь ажиллаж чадаж байгаа юм уу, үгүй юм уу? Тэр баланс алдагдлаа гээд байна шүү дээ. Тэгвэл балансаа яаж засах юм бэ? Ингээд буцаад удирдамж, тодорхой удирдамж өгөөд, энэнийхээ дагуу 2025 оныхоо тайлан төлөвлөгөө дээрээ та нар дахиад энэ асуудлуудаа орж ирж засаад, түрүүн 30 хэдэн хувьтай байсан бол 40 хэдэн хувь, 70 хувь, 60 хувь, 70 хувь, 80 хувь хүрлээ гэсэн ийм зүйл рүү бид очиж байх ёстой шүү дээ.

Хуультай холбоотой асуудлуудыг эндээ хийе. Үйл ажиллагааны хүрээнд чандлан сахих ёстой, тэр тусмаа жишээ нь өөрөө хэлээд байна шүү дээ. Жишээ нь аймгуудын төрийн албаны зөвлөлтэй холбоотой асуудлууд байж байна. Бид өөрсдөө хүнийг нь томилдоггүй болохоор гээд байна шүү дээ та нар. Тэгвэл тэрийг томилох, зайлшгүй томилж байгаа хүнд нь албан шаардлага хүргүүлж байдаг, энэ нь өөрөө зөвлөмж биш, хэрэгждэг, бүр зайлшгүй хэрэгждэг байх ийм бодлогуудыг авч байж бид өнөөдөр төрийн алба маань хатуу, төрийн алба маань чанд байх ийм нөхцөл байдал бий үүснэ шүү дээ. Би энийг л хэлээд байгаа юм.

Тийм болохоор дараагийн Байнгын хорооны дараагийн хурал дээр энэ асуудлыг дахиад нэг авч хэлэлцэх зайлшгүй шаардлага байна гэж харж байна. Тийм болохоор эндээс тайлан хэлэлцсэнтэй холбогдуулан тодорхой чиглэл, дүгнэлтийг гаргаж, Байнгын хороогоор зайлшгүй хэлэлцэх нь зүйтэй байна гэсэн ийм зүйлийг хэлье. Тэгээд та бүхэнд амжилт хүсье. Ямар ч байсан хийсэн зөндөө ажилтай байна. Ажлыг чинь өнөөдөр бол үгүйсгэсэн юм алга байна. Гэхдээ зайлшгүй засах зүйлүүд байгаад байгаа юм. Удирдамж чиглэл өгөх зайлшгүй, чиглэл зайлшгүй өгөх ийм асуудал байна гэдгийг хэлье. Ингээд гишүүд үг хэлж дууслаа. Төрийн албаны зөвлөлийн 2024 оны үйл ажиллагааны тайланг хэлэлцэж дууслаа. Дараагийн хуралдаанаар тайлантай холбогдуулан дүгнэлт, тодорхой асуудал дахин хэлэлцэх болно. Өнөөдрийн 2024 он, Төрийн албаны зөвлөлийн 24 оны үйл ажиллагааны тайланг хэлэлцэж дууслаа.

18.01 цаг

***Хоёр.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 04 дүгээр дүгнэлт
/Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.1 дэх
хэсгийн холбогдох заалт Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх,
үргэлжлэв/***

2 дахь асуудалдаа оръё. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 4 дүгээр дүгнэлтийн талаар боловсруулсан Улсын Их Хурлын тогтоолын төсөлтэй холбоотой 2 дахь асуудал байна. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.1 дэх хэсгийн холбогдох заалт Монгол Улсын Үндсэн

хуулийг зөрчсөн эсэх асуудлыг, маргааныг хянан шийдвэрлэсэн тухай үргэлжлүүлэн хэлэлцэнэ.

Төрийн байгуулалтын байнгын хороо 2025 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн хуралдаанаар Үндсэн хуулийн цэцийн 4 дүгээр дүгнэлтийг хэлэлцэж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонх хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж үзсэн байгаа. Ингээд Байнгын хорооны хуралдаанаар Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн авах боломжгүй гэж үзсэнтэй холбогдуулан боловсруулж байгаа Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар хэлэлцье гэсэн. Тэгэхээр гишүүд өөрсдийнхөө саналуудыг хэлээд, ер нь Улсын Их Хурал руу орох тогтоолын төсөл дээр тодорхой үндэслэлүүдийг гаргаж өгнө. Урьд өмнө бид хүлээж авах нь, хүлээж авахгүй гэсэн ийм тогтоолын төсөл гаргаад л Цэц рүү явуулаад байгаа шүү дээ. Тийм болохоор эртээд гишүүдээс гарсан саналын дагуу тогтоолын төсөлтэй уялдуулаад, холбогдуулаад тодорхой дүгнэлт, үндэслэлүүдийг явуулах нь зүйтэй юм гэж үзсэн. Тэгээд энэ талаар. Тогтоолын төсөл байгаа тийм ээ? Төслийг та бүхэнд урьдчилсан байдлаар бэлдэж, та бүхэнд танилцуулсан байгаа. Тэгээд тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт асуух, нэмэлт саналтай гишүүд байна уу? Гишүүд нэрсээ өгнө үү саналтай гишүүд? Баярбаатар, Зулпхар. Зулпхар гишүүнээр тасаллаа. Баярбаатар гишүүн.

Б.Баярбаатар: Оройн мэнд хүргэе. Энэ тогтоолын төслийг дэмжиж байна. Цэцийн энэ дүгнэлтийг хүлээж авах боломжгүй байгаа юм. Яагаад гэхээр сонгуулийн тогтолцоо 2000, 90 оны сонгуулийн тогтолцоо пропорциональ, мажоритарын холимог явагдаж байсан юм. 2008 оны сонгууль мажоритар буюу томсгосон тойргоор явагдсан юм. Ингээд дараа нь 20 оных, 24 оных бүүр ингээд бүсчилсэн хэлбэр лүү ороод явчихсан. Тэгээд энэ дээр яагаад би энэ үндэслэл хэлж байна вэ гэхээр Үндэсний аюулгүй байдал буюу Монгол Улсын язгуур эрх ашгийн нэг зүйл нь үндэсний эв нэгдэл гэж байдаг юм. Сонгууль гэдэг ерөөсөө энэ үндэсний эв нэгдлийг хангах ийм зарчимд заавал тулгуурлаж байх ёстой гэж үздэг.

Гэтэл энэ томсгосон тойргийн ганц аюул нь энэ бүр улс төрийн нам хамаарахгүйгээр нам дотор нь талцал хуваагдлыг бий болгодог, хоорондоо өрсөлдүүлэх нөхцөл байдлыг буюу энийг дагасан нам, иргэд, сонгогчдыг хуваах талцал хуваагдалд хүргэдэг ийм нөхцөл байдал үүсгэдэг юм. Гэтэл энэ чинь бүр ингээд нэг намын 4 нэр дэвшигчийг байхад 4-үүлэнг нь биш, 1-ийг нь дугуйлбал хүчинтэй гээд үзчихвэл энэ хуваагдал чинь яг бодит байдлаараа хэрэгжих нөхцөл байдал үүсчихдэг юм. Энэ бодит болсон жишээ нь 2008 оны сонгууль байдаг юм. Том мажоритар, тэгтэл тэнд бол дутуу дугуйлбал тэр саналын хуудас хүчинтэй байсан байхгүй юу. Ганцханыг дугуйлсан ч хүчинтэй, 4-ийг дугуйлсан ч хүчинтэй байсан. Гэтэл яг тэр үед чинь нөгөө санал тоолох машин ороогүй, бүгд гар тооллоготой явдаг байсан. Сүүлд нөгөө саналын хуудаснуудыг тоолоод үзэхэд ганцхан хүнийг дугуйлсан 3500 саналын хуудас гарч ирсэн байхгүй юу.

Тэгээд ерөөсөө тэр сонгуулийн сурталчилгаа нь өөрөө зөвхөн намайг дугуйлаарай гэдэг байдлаар ингээд явчихдаг. Нэг ёсны багийн тоглолт алдагдана. Багийн тоглолт гэдэг маань өөрөө эв нэгдэл байхгүй юу. Энэ чинь цаад агуулгаараа нөгөө сонгогчдоо сум дотор нь бараг 4 мандаттай бол 4 хуваадаг ийм нөхцөл байдал үүсэх юм байгаа юм. Тэгэхээр энэ үндэсний аюулгүй байдал, Монгол Улсын язгуур эрх ашгийн нэг зүйл бол үндэсний эв нэгдэл гэдэг зарчим байгаа учраас энэ хэрвээ одоо энэ Цэцийн дүгнэлтийг хүлээж авбал энэ эв нэгдэл

хангагдах боломжгүй нөхцөл байдал руу илүү гүнзгий орно гэж ийм үндэслэлийг бүр тусгаж өгмөөр байгаа юм энэ дээр, тийм.

Тэгэхээр энэ олон сонгуулийн тогтолцоо байдаг. Бид олон сонгуулийн тогтолцоог янз бүрийн байдлаар бид өнгөрсөн 9 удаагийн сонгуульд хэрэглэж үзсэн. Монголынхоо нөхцөлд нутагшуулж, тааруулж янз бүрийн байдлаар л үзсэн. Төгс юм гэж мэдээж хаана ч байхгүй. Тэгэхдээ өнөөдрийн бид Үндсэн хуулиараа тунхаглаад зарлачихсан Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр оруулчихсан байгаа пропорциональ мажоритарын энэ холимог тогтолцоо бол өнөөдрийн түвшинд Монгол Улсдаа бол яг тохирч байгаа тогтолцоо гэж харж байгаа. Тийм учраас энэ чигээр нь ямар нэгэн байдлаар энэ хуулийн өөрчлөлт оруулахгүйгээр нэг дор хаяж 3 сонгуулийн цикл явуулах шаардлагатай гэсэн ийм байр суурь байгаа.

Ер нь өнгөрсөн хугацаанд Сонгуулийн хуультай холбоотойгоор хэд хэдэн ийм Цэцийн дүгнэлтүүд сүүлийн үед орж ирж байна. Магадгүй зүгээр хүний эрхийн зөрчилтэй холбогдолтой ийм зүйлүүд байж магадгүй. Тэгэхдээ энэ сонгууль, сонгуулийн сурталчилгаа, өрсөлдөөн, энэний цаана үлдэж байгаа иргэд, сонгогчид, нэр дэвшиж ялсан, тангараг өргөсөн Улсын Их Хурлын гишүүд, иргэдийн Хурлын Төлөөлөгчид ялагдсан гээд олон зүйлүүдийн эрх ашиг байдаг учраас аль болох тэнцвэрийг нь хангасан, голыг нь олсон, зарчимд суурилсан ийм зүйл, заалт дээрээ бид тулаад явж байхгүй бол хэсэг нөхдийн эрх ашгийг дагасан ч юм уу, нэг ийм болохгүй зүйлийг харангуутаа хэт туйлширсан байдлаар асуудалд хандаж ингэж явах нь өөрөө парламентын хувьд буруу гэж харж байгаа. Тийм учраас би энэ санааг 1 дүгээрт тусгая.

2 дугаарт гэвэл энэ Цэцийн дүгнэлтийг ямар нэгэн байдлаар хүлээж авах боломжгүй гэсэн саналыг хэлье.

Ж.Бат-Эрдэнэ: Зулпхар гишүүн саналаа хэлье.

С.Зулпхар: Энэ Цэцийн дүгнэлтийг бид бол угаасаа хүлээж авахгүй гэдгээ илэрхийлсэн, тайлбараа өгч байна. Тайлбарыг уг нь бид өгсөн биш аль хэзээ 1993 онд Цэц өөрөө өгчихсөн байхгүй юу анх. Яг үүнтэй адилхан маргаан Цэц дээр гарч байсан. Тухайн үед Цэц энэ бол Үндсэн хууль зөрчөөгүй гэдэг ийм л шийдвэр гаргасан. Тэрнээс хойш Монгол Улс бол Монгол Улсад Үндсэн хууль бол дахиж бид шинэ Үндсэн хууль батлаагүй. Монгол Улс улс төрийн дэглэмийн хувьд ардчилсан дэглэмтэй улс хэвээр байгаа. Төрийн байгуулалтын хувьд парламентын жишээ нь засаглалтай улс хэвээр байгаа, төрийн байгууламжийн хувьд нэгдмэл улс хэвээр байгаа. Тэгэхлээр энэ шийдвэр өнөөдөр ингэж Цэц гаргаж байгаа нь өөрөө асуудалтай байна гэж байгаа юм.

Яах вэ бид тайлбар хийх ёстой. 1 дүгээрт энэ чөлөөт сонголт гэж юу юм бэ гэдэг тайлбарыг энэ Олон улсын байгууллагын тайлангуудыг аваад уншсан ч гэсэн, эрдэмтдийн, судлаачдын өгүүллүүдийг аваад уншсан ч гэсэн нэг л зүйл хэлж байгаа шүү дээ. 2 болон түүнээс дээш хувилбараар сонголт хийх боломжийг олгоно гэдэг бол энэ өөрөө чөлөөт сонголт юм гэж байгаа юм. Энийг хангасан байх энэ зарчим бол өөрөө чөлөөт сонголтыг илэрхийлнэ гэж байгаа юм. Тэгэхлээр сонгууль, сонгуулийн тогтолцоотой уялдсан байдалтайгаар бий болсон нэрсийн жагсаалт дээр 2 болон түүнээс илүү сонголт хийх хувилбарыг бий болгосон байгаа бол энэ бол чөлөөт сонголт хийгдэж байна гэж үздэг. Тэгээд энэ үүднээс нь манай жишээ нь Үндсэн хуулийн цэцийн гишүүд онолынхоо маргааныг бүрэн жишээ нь

хийх ёстой. Бид онолын маргаан дээр суух бол онолын маргаанаа сайн хийж байж, тэд маань онолын маргааны үндэслэлийг зөв гаргах ёстой гэж ойлгож байна.

Энэ үүднээс 2 асуудал гараад ирлээ шүү дээ. Эхнийх нь өөрийнхөө шийдвэрийг бол тодорхой хугацааны дараа үгүйсгэчихсэн. 2 дахь нь угаасаа үндсэн зарчим нь тодорхой юман дээр биш гэдэг шийдвэр гаргаж байгаа нь асуудалтай байна гэж байгаа юм. 3 дахь зүйл яг саяын санал өгөхтэй холбоотой асуудал дээр мэдээж хэрэг саналаа хэрэглэнэ гэдэг бол чөлөөт сонголт бол absolute эрх. Гэхдээ саналаа хэлэхтэй холбоотой энэ үйл явцыг бол absolute биш тодорхой хэмжээнд зохицуулж болдог ийм эрх гэж үздэг. Та бүхэн мэдэж байгаа шүү дээ, жишээ нь зарим нь бол, зарим улсад тодорхой сонголтууд байдаг. Жишээ нь энэнтэй холбоотойгоор нь аваад үзвэл энэ бол туйлын жишээ нь эрх бол биш шүү гэдэг талаас нь ойлгож.

Нөгөө талдаа энэ дээр яагаад энэ туйлын биш эрхээр зохицуулсан гэхлээр зэрэг төлөөллийг бий болгохын тулд, төлөөллийг гаргахын тулд энэ бол тухайн сонгогчийн үүрэг шүү гэдэг талаас нь хийсэн зохицуулалт юм байгаа юм. Энэ үүрэгжүүлж байгаа хэлбэр шүү дээ. Төрийн байгууламжийн хувьд нэгдмэл улсад бүсчилсэн байдлаар сонгууль явуулахад энэ дээр санал гээгдэх биш, харин төлөөлөл гээгдчих ийм эрсдэл үүсэж байгаа бол энийг давсан ийм зүйл байгаа учраас энийг бид хүлээж авах боломжгүй гэж үзэж байгаа юм. Тэгэхлээр бидний хувьд бидний жишээ нь Улсын Их Хурлын ТББХ-ноос хорооноос гаргаж байгаа энэ Үндсэн хуулийн цэцийн шийдвэрийг хүлээж авахгүй гэдэг энэ байр суурь бол гарцаагүй зөв гэж ойлгож байна. Энэ дээр Үндсэн хуулийн цэцийн гишүүд маань өөрсдөө мэргэшсэн улсууд, энэ чиглэлээр нарийн судалгаа хийдэг улсууд учраас энэ асуудлаа дахиж өөрсдөө судалж харах байх гэсэн бодолтой байна. Баярлалаа.

Ж.Бат-Эрдэнэ: Одбаяр гишүүн.

Э.Одбаяр: Байнгын хорооны гишүүдийнхээ оройн амгаланг эрье. Тэгээд Баярбаатар гишүүн, Зулпхар гишүүдийн хэлж байгаа саналтай санал нэг байгаа. Тэгээд энэ Цэцийн дүгнэлт бол яах аргагүй бид төрийн байгууламжийн хувьд нэгдмэл байх ёстой. Дээрээс нь бид энэ холимог тогтолцоо, томсгосон тойрог гэдэг зүйл маань өөрөө энэ үндэсний эв нэгдлийг сахиулах тал дээр чухал ач холбогдолтой гэж үзэж байгаа учраас ялангуяа сонгуулийн энэ тогтолцоо дээр хэдүүлээ жоохон прагматик байх ёстой юм байна лээ. Нам дотроо мууддаг, өөдөөс харсан өрсөлдөж байгаа намтайгаа мууддаг. Эргээд сонгуулийн кампанит ажил дуусаад, парламент бүрдээд ороод ирэхэд хажуу тал руугаа, урд тал руугаа баахан хэрүүл хийчихсэн хүмүүс баг болж ажиллахад аягүй төвөгтэй байдаг.

Тэгээд манай газар нутаг том, хүн ам сийрэг суурьшсан энэ онцлогоо, улсын онцлогоосоо шалтгаалаад бид иргэдийгээ аль болох энэ улс төржилтөөс талцлаас жоохон хол байлгах тал руу төр түшиж байгаа, гүйцэтгэх засаглалд ажиллаж байгаа, хууль баталж байгаа хүмүүс маань, жоохон хариуцлагатай алба хашиж байгаа хүмүүс нь бүгдээрээ тэр тал дээр нэгдмэл байх ёстой юм байна лээ. Тэгээд мэдээж сонгууль болоод дуусдаг сум, орон нутагт талцаад хэрэлдээд үлддэг, Ордонд болохоор ингээд арай өөр юм ингээд яваад өгдөг. Тэгээд энэ байдлаас хэдүүлээ жоохон юу гэдэг юм нийгмээ талцуулах сэдвээс л аль болох зайлсхийж явах ёстой гэж бодож байгаа.

2-т бүтээмж тал руугаа энэ хэрүүл уруул, улс төржилтийг бага байлгах нь үр дүнтэй. Ялангуяа ингээд улс орны өмнө тулгарсан асуудлуудаа эвсээд нэгдээд, нийлээд шийдье гээд явж байгаа энэ хамтарсан Засгийн газар байгуулаад явж байгаа энэ модель бол ялангуяа. Одоо энэ бүсийн хөгжлийн уулзалт гээд нэг арга хэмжээ зохион байгуулаад, түүн дээр нь Засгийн газарт нь орж ажиллаж байгаа сайдууд нь бүрэн бүрэлдэхүүнээрээ, тухайн бүсээс сонгогдсон гишүүд нь нам харгалзалгүйгээр ингээд бүсийнхээ асуудлыг, тухайн аймаг, бүсэд хамаарах аймаг, сумын иргэдийн Хурлын Дарга, аймгийн иргэдийн Хурлын Төлөөлөгч нартайгаа тойроод, бүгдээрээ тойроод хэлэлцээд, суугаад асуудлуудаа яриад, шийдээд явж байгаа, шийдлүүдээ ярилцаж байгаа энэ хувилбар бол бас нөгөө талдаа юу вэ гэхээр эв нэгдлийг хангаж, хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлж, төрийн бодлого шат шатдаа уялдаатай гаргахын төлөө хичээгээд ажиллаж байгаа нэг арга хэлбэр гэж ойлгож байгаа.

Тэгэхээр бүх талаараа энэ сонгох сонголтыг өөрөөр хэлбэл хязгаартай болгоно гэдэг бол яг улс төрийн намын амьдралаар олон жил явсан, сонгууль хийж үзсэн хүмүүс энэ зовлон, жаргалыг нь ойлгох байх. Олон удаа нэр дэвшээд ч ялагдаж үзсэн хүмүүс. Яах аргагүй энэ нам дотооддоо гишүүдээ хагалдаг, санал өгсөн, нөгөө дэмжиж ажилласан хүмүүсээ дотор нь хуваадаг аягүй төвөгтэй хэрүүл рүү ордог ийм сэдэв байгаа юм. Тэгэхээр энэ дээр Байнгын хорооныхоо гишүүдтэй санал нэг байгаагаа илэрхийлж байна. Тэгээд та бүхэнд баярлалаа.

Ж.Бат-Эрдэнэ: Гишүүд саналаа хэллээ. Ер нь ойлгомжтой, энэ тогтоолыг Байнгын хороо хүлээж авахгүй байх нь зүйтэй гэж үзсэн. Энэнтэй уялдуулаад тогтоол гарч байгаа. Тэгээд тогтоол дээр саналуудаа хэллээ. Санал хураахгүй. Ер нь бид чинь сая Үндсэн хуульдаа өөрчлөлт оруулаад, 126 гишүүн бүхий холимог тогтолцоог бол Үндсэн хуульдаа өөрчлөлт оруулсан шүү дээ. Тэгээд энэний үр дүнд өнөөдөр үр дүн маш сайн гарсан гэж үзэж байгаа. 5 намын төлөөлөл парламентад орж ирсэн. Ингэснээрээ олон ургалч үзэл, улс төрийн намуудын бодлого, энэ нь улс төр лүү орох, энэ нь намын, Улсын Их Хурлын парламентын бодлого болж гарах, хяналт сайжрах, урьд өмнө нь 2 нам л хоорондоо үзээд яваад байдаг. Нэг нь цөөнх болдог, нэг нь олонх болдог. Ингээд явдаг байсан бол одоо 5 намын төлөөлөл орж ирж байгаа. Тэгэхээр энэнтэй уялдаад өнөөдөр энэ бүтэн дугуйлна гэж бид яриад байгаа шүү дээ. Бүтэн дугуйлна, сонгох эрхээ бүрэн хэрэгжүүлэх, энэ парламентын олон намуудын хоорондын тогтолцоог сайжруулах, харьцааг сайжруулах, бодлого тэгшлэх энэ хүрээнд энэ Цэцийн дүгнэлтийг хүлээж авахгүй байх нь зүйтэй юм гэж үзсэн. Байнгын хороо ингэж үзсэн.

Ингээд Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж үзсэнтэй холбогдуулан боловсруулсан Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж дууслаа. Саяын гишүүдийн хэлсэн саналыг, ерөнхий утга байгаа. Тэгэхдээ энэ дээр илүү дахин оролцуулж, боловсруулан гаргая.

18.15 цаг

Гурав.Хууль, тогтоолоор үүрэг, чиглэл болгосон Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийн тайлан /үргэлжлэл/

Дараагийн асуудалдаа оръё. Хууль, тогтоолоор үүрэг чиглэл болгосон Улсын Их Хурлын тогтоолын, Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийн тайлан үргэлжилж хэлэлцэнэ. ТББХ-ны 2025 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн

хуралдаанаар Хууль, тогтоолоор үүрэг болгосон, үүрэг, чиглэл болгосон Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийн тайланг хэлэлцэж, дараагийн хуралдаан хүртэл хойшлуулж, үргэлжлүүлж хэлэлцэхээр болсон байгаа. Тайлантай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж дууссан. Ингээд одоо үг хэлэх гишүүд байна уу? Алга байна.

Ямар ч л байсан бид ингэсэн шүү. Ер нь бол хар даа, одоо энэ Улсын Их Хурлаас өгч байгаа үүрэг, чиглэл биелэхгүй зүйлүүд маш их байгаа шүү дээ. Биелэхгүй зүйлүүд маш их байж байгаа. Би жишээ нь, бүр жишээ татсан шүү дээ, заачихсан шүү дээ. Хүнс, хөдөө аж ахуй юуны, Байгаль орчин, хөдөө аж ахуйн байнгын хороон дээр гаргасан шийдвэр өөрөөр хэлбэл малын эрүүл мэндтэй холбоотой гаргасан шийдвэр өнөөдөр эндээс 1 ч шийдвэрийг ЗГ дээр авч хэлэлцэж, хэрэгжүүлсэн зүйл байхгүй байгаад байгаа юм. 2 жил өнгөрч байна. Дээрээс нь, тийм Байнгын хорооны тогтоол шүү дээ.

Дээрээс нь Улсын Их Хурлаар гаргасан ноднин жил гаргасан 31 дүгээр тогтоол буюу гаалийн татварыг тэглэх тухай, тэглэсэнтэй холбогдуулан Улсын Их Хурлын тогтоол гарсан. Улсын Их Хурлын тогтоол дээр тариаланчдыг дэмжих, 100 мянга хүртэл тонн үрийн буудайг буюу тонн хүртэл буудайг нөөцөд авах нэг. 2 дугаарт тэр юутай холбоотойгоор лабораторийн асуудлуудыг сайжруулах гээд ингээд 7, 8 том заалтууд орж ирсэн. Өөрөөр хэлбэл гурилын гаалийн татварыг тэглэсэнтэй холбогдсон зохих хэрэгжүүлэх ийм арга хэмжээнүүдийг заагаад ингээд явуулсан шүү дээ. Сая Улсын Их Хурал дээр хэлэлцэж байхад жишээ нь Хөдөө аж ахуйн сайд энэ тогтоолтой холбоотой нэг ч үг гав хийж ярьсангүй. Нэг ч үг ийм тогтоолын дагуу бид ийм арга хэмжээ зохион байгууллаа, ингэж, ингэж үр дүн гарлаа гэсэн нэг ч асуудал яригдаагүй. Тэгэхээр энэнтэй холбоотойгоор Улсын Их Хурал нэгэнт мэргэжлийн байгууллага, мэргэжлийн Байнгын хорооноосоо гаргасан чиглэл, шийдвэрүүдийг ЗГ дээр хэрхэн хэрэгжүүлсэн гэдэг тал дээр ингээд цааш цаашдаа бүх Байнгын хороон дээр бүх чиглэлийнхээ дагуу энэ гаргасан тогтоол, шийдвэрүүд нь, чиглэлүүд нь хэрэгжсэн, хэрэгжээгүй тал дээр нь авч хэлэлцэж ингэж жишиг шинээр жишиг тогтоох нь зүйтэй юм гэж үзээд энэ асуудлыг дараагийн Байнгын хороо, өөрөөр хэлбэл 30-ны хэлэлцсэн асуудлыг бид сунгаж, өнөөдөр ингээд дахин хэлэлцэж байгаа юм.

Цаашдаа нэг ийм жишиг тогтоох зайлшгүй шаардлагатай байж байна. Тэгэхгүй бол бид нараас гаргасан, Байнгын хороодоос гаргасан зайлшгүй хэрэгжих ёстой зүйл маань нөгөө усанд хаясан чулуу мэт ингээд цаашаа хэрэгжихгүй алга болчихоод байгаа юм гэж. Тийм. Тэгэхээр энэ танай байгууллагаас эртээд танилцуулга дээр орж ирсэн тийм ээ, нийт 569 заалт бүхий заалтыг хяналтаас хасъя гэсэн тийм үү? Энэ нь тодорхой хэмжээгээр биелсэн дүгнэлт гарсан заалтууд гэж байгаа шүү дээ. Тэгэхээр энэ болгон чинь бүх Байнгын хороодоор орох байх. Бүх Байнгын хороодоор ороод, хэлэлцэгдсэний дараа Төрийн байгуулалтын байнгын хороон дээр бүгдийг нь татаж авчирч байгаад, эндээс тодорхой хэмжээний шийдвэр гаргаад, дахиад Байнгын хороогоор оролцуулаад энийг хяналтаас хасах. Тэгээд дээрээс нь өөр зарим нэгэн тийм хасах, үгүйг шийдэх, дээрээс нь зарим нэгэн чиглэл өгөх ийм зайлшгүй шаардлага гарах байх шүү. Тийм болохоор энэ дараагийн хуралдаанаар тодорхой дүгнэлттэйгээр оруулж ирж, Байнгын хороогоор хэлэлцэнэ гэж байгаа шүү. Ингээд гишүүд саналаа хэлж дууслаа. Хууль, тогтоолоор үүрэг болсон, үүрэг, чиглэл болсон Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийн тайланг хэлэлцэж дууслаа.

18.20 цаг

Төрийн байгуулалтын байнгын хорооны хэлэлцэх асуудал дууссан тул өнөөдрийн хуралдааныг өндөрлөснийг мэдэгдье. Баярлалаа.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА